



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

ЖИЛИЙН ТАЙЛАН  
2021

Хэвлэлийн эх бэлтгэлийг А.Чинбат  
Хавтасны зургийг Б.Баатар



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



ЖИЛИЙН ТАЙЛАН  
2021



# ГАРЧИГ

---

## АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ

Ардчиллын институцийг бэхжүүлэх нь.....	6
Иргэний оролцоог дэмжих нь .....	18

## ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь .....	22
Хүний эрх .....	28
Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг дэмжих нь.....	34

## НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Төсвийн хариуцлагыг сайжруулах нь.....	39
Эрдэс баялгийн салбарт сайн засаглалыг дэмжих нь.....	57

САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	69
-------------------------	----

# ӨМНӨХ ҮГ

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын амаргүй цаг хугацаанд Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын хамт олон бид ажлын цар хүрээгээ хүмилгүй, хэвийн явуулах сорилтын дунд нэгэн жилийн ажил үйлс маань өрнөлөө. Энэ хугацаанд улс орныхоо хөгжлийн бодлого боловсруулах үйл явцыг судалгаа шинжилгээгээр дэмжих, иргэний нийгмийн үр нөлөөтэй оролцоог нэмэгдүүлэхийг зорьж төрийн болон төрийн бус байгууллага, бие даасан судлаачидтай идэвхтэй хамтран ажиллалаа. Ийнхүү 2021 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааныхаа тайланг олон нийтэд хүргэж буйдаа баяртай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлтөд шүүхийн бие даасан хараат бус байдлыг гүнзгийрүүлэх, улс төрийн намын шинэчлэл, ил тод байдлыг сайжруулах, нийтийн баялгийг урт хугацааны бодлогод түлгүүрлан ашиглаж, үр өгөөжийг иргэддээ тэгш, шударга хүртээх зэрэг ардчилсан хөгжлийн бодлогын чухал асуудлууд тусгагдсан билээ. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд энэхүү өөрчлөлтийн дагуу өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн үйл явцад ННФ идэвхтэй оролцон шүүхийн тухай хууль, улс төрийн намын тухай хууль, эрдэс баялгийн салбарын хуулиудын өөрчлөлтөд хөндлөнгийн бие даасан судлаачдын судалгаанд үндэслэсэн санал зөвлөмж оруулах, олон талын төлөөллийг оролцуулсан бодлогын үүлзалт хэлэлцүүлгүүд өрнүүлэх, хуулийн шинэчлэлийн ажлын хэсэгт багтан олон улсын стандарт, сайн түршлагыг танилцуулах, шаардлагатай тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллаж ирлээ. Тухайлбал, шүүхийн шинэтгэлийг дэмжих хүрээнд шүүхийн тогтолцоо, шүүхийн шийдвэрийн цахим сангийн талаар судалгаа хийж Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлалыг бататгах мэдээллийн сан

(www.shuukh.forum.mn)-г үндэслэлээ. Шүүхийн шийдвэрийн тэтгэлэгт судалгааны хүрээнд 2021 онд нийт 13 судалгаа дөрвөн цувралаар хэвлэн шүүгч, хуульч болон эрдэмтэн судлаачдад хүргээд байна. Шүүхийн хараат бус, бие даасан, нээлттэй, ил тод байдал, үйл ажиллагаагаа үр нөлөөтэй явуулах нөөц, зохион байгуулалт, хариуцлага болон иргэдийн шүүхэд итгэх итгэлийг үнэлэх Шүүхийн индексийн судалгааны арга зүйг боловсруулж сүүр мэдээлэл цуглуулж боловсруулаа.

Эрдэс баялгийн салбарын эрх зүйн шинэчлэлд чиглэсэн хөндлөнгийн хараат бус судалгаа, шинжилгээг дэмжихийн сацуу Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын Үзэл баримтлалыг тодорхойлоход төрийн оролцоо, баялгийн өмчлөл, татвар, санхүүгийн орчин, дэд бүтэц, орлогын хуваарилалт, байгаль орчин, нийгмийн сөрөг үр дагавраас сэргийлэх зэрэг санал бүхий зөвлөмж боловсруулан салбарын яаманд хүргүүлэв. Мөн Үндэсний баялгийн сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн төслүүдэд санал шүүмж хүргүүлээд байна.

Үндсэн хуульд туссан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх ажил үргэлжилж байна. Энэ үйл явцад салбарын эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн оролцоог хангах, тэдний санал зөвлөмжийг бодлого боловсруулагчдад хүргэхэд анхааран шинэчлэлийн хүрээнд яригдаж буй гол асуудлууд болох намын хатуу гишүүнчлэл, төрийн санхүүжилт, ил тод байдал, хяналт хариуцлага гэх мэт сэдвээр олон улсын чиг хандлага, дотоодод тулгарч

буй асуудлуудыг хэлэлцэж шийдэл санал болгосон нийтлэл, ярилцлага, хэлэлцүүлгүүдийг цувралаар хүргэлээ. Түүнчлэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, Хүний эрхийн газар, Венецийн комисс, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн зэрэг олон улсын мэргэжлийн байгууллагуудаас хуулийн шинэчлэлтэй холбоотой санал зөвлөмж авах ажлыг зохион байгуулж бодлого боловсруулагчдад техникийн туслалцаа үзүүлэв.

“Ковид-19” цар тахлын амаргүй нөхцөлд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг хамгаалах чиглэлээр ННФ нь Хүний эрхийн форумтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох талуудад хүргүүлээ. Хүний эрхийн форум 2016 оноос эхлэн ХЭҮК-той хамтран Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлах чиглэлээр санаачилга гарган ажилласан бөгөөд энэ онд тус хууль батлагдсан нь онцлох үйл явдал байв. Мөн Хүний эрхийн форумыг хүний эрхийн салбарын нэг гол оролцогч болсныг батлан харуулсан үйл явдал бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор зохион байгуулагдсан “Хүний эрхийн форум – 2021” чуулганы үндсэн болон салбар хуралдаануудад илтгэл, мэдээлэл танилцуулахын зэрэгцээ ХЭҮК-ын гишүүн сонгон шалгаруулах Ажлын хэсэгт тус форумын төлөөлөл орж ажиллаж буй явдал юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн үеэр ННФ-ын дэмжлэгтэйгээр “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн байгууллагууд сонгуулийн санхүүжилт, сонгогчдын нэрийн жагсаалт, автоматжуулсан систем, сонгуулийн үеэрх нийгмийн сүлжээ болон хэвлэл мэдээллийн сурталчилгаанд мониторинг хийлээ. Сонгуулийн өдөр 107 сайн дурын ажиглагч нийслэлийн 48, орон нутгийн таван хэсгийн хороонд,

мөн иргэний нийгмийн ажиглагчид Сөүл, Токио, Нью-Йорк хотод санал хураах, тоолох, дүн гаргах үйл явцад хяналт тавилаа. Улмаар сонгуулийн зардлын тайлан хүлээн авах, хяналт тавих цахим систем хөгжүүлэхэд Аудитын байгууллагад дэмжлэг үзүүлж, уг системийг Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын 18, 28 дугаар тойргийн нөхөн сонгуулийн үеэр ашигласан нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, Хүний эрхийн газрын тайланд сайшаан тэмдэглэгджээ.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд “Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт”, “Мөрдөх албаны талаарх харьцуулсан судалгаа”, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа: Тулгамдаж буй асуудал” зэрэг 10 гаруй судалгаа шинжилгээг олон нийтэд хүргэлээ. Мөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулах тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд гаргасан судалгаа, дүн шинжилгээнд түлгүүрлан “Хохиролгүй барагдуулъя” сэдэвт кампанит ажлыг өрнүүлээ. Үүний зэрэгцээ хохирол барагдуулах хүрээнд жишиг тогтоох зорилгоор стратегийн өмгөөллийн төслүүдийг дэмжиж ажиллалаа. Эдгээр хүчин чармайлт үр дүнд хүрч, энэ асуудлаар бодлогын шинэчлэл өрнөж эхлээд байна.

Төрийн зүгээс төсөв, санхүүд тавих хяналтаа сайжруулах, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлого шийдвэрт иргэдийн дуу хоолойг тусгах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан хараат бус судлаачдаас бүрдсэн “Төсвийн Зөвлөл” Ковид-19 цар тахлын эсрэг төсвийн бодлого, цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, төсвөөс гадуурх зарцуулалт, төсвийн тодотгол, Үндэсний баялгийн сангийн болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл зэрэг асуудлыг хэлэлцэн дүн шинжилгээ хийж санал, зөвлөмж гаргалаа. Түүнчлэн олон улсын байгууллагуудтай өрнүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас зохион байгуулдаг “Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа”, Дэлхийн өрсөлдөх

чадварын тайлангийн Бизнесийн удирдах ажилтнуудын санал асуулгын судалгааны Монгол Улсын ээлжит үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Бид хуулийн хэрэгжилтэд үнэлгээ мониторинг хийх, бодлогын судалгаа шинжилгээг дэмжих зэрэг уламжлалт үйл ажиллагаанаас гадна нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах, өгөгдөлд шинжилгээ хийх Хакатон зохион байгуулах, нийтэд ил болсон мэдээллийг нээлттэй өгөгдөлд хөрвүүлэх, олон нийтэд хандсан интерактив контент бэлтгэх зэрэг шинэлэг үйл ажиллагааг бусад төрийн бус байгууллага, хөндлөнгийн бие даасан судлаачтай хамтран хэрэгжүүлж байна.

Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн байгууллагууд оролцох хуулиар олгогдсон нэг боломж нь нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах юм. 2016 оноос эхэлсэн энэ үйл ажиллагаанд ННФ нийт 41 төсөл дэмжин тэтгэлэг олгосноос эдүгээ 47 өмгөөллөөс 20 нь эцэслэн шийдвэрлэгдэж багагүй амжилтад хүрээд байна. Үүнээс эрдэс баялгийн салбарт холбогдох 11 хэрэгт нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь болон зарим хэсгийг ханган шийдвэрлэжээ. Зөвхөн 2021 онд гэхэд энэхүү нийтийн өмгөөллийн үр дүнд орон нутагт 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэв. Түүнчлэн КОВИД-19 цар тахлын үед төрийн байгууллагуудын авсан хандив түслэмжийн мэдээллийг ил болгох, орон нутаг дахь хүүхдийн эмнэлгийн чанаргүй барилга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн татварын хөнгөлөлт болон мэдээллийн үйлчилгээг тэдэнд хүртээмжтэй болгох зэрэг асуудлаар нийтийн өмгөөлөл хийсэн нь тодорхой үр дүнд хүрлээ. Нийтийн өмгөөллөөр ажиллах иргэний нийгмийн байгууллагуудыг ийнхүү тууштай дэмжиж ирснээр сүүлийн жилүүдэд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дагнан ажиллах байгууллагууд бий болж, зарим нь хуульчдын баг бүрдүүлэн өөрийн гэсэн хөтөлбөртэй болжээ.

“Уул уурхайг өгөгдлөөр урлахуй”, “Орон нутгийн төсвөө хянацгаая!” сэдвийн хүрээнд бусад төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан Хакатонд дата шинжилгээ, график дүрслэл, сэтгүүл зүйн ур чадварыг нэгтгэсэн залуус хэд хэдэн багаар ажиллан, орон нутгийн төсвийн зарцуулалт, хандив дэмжлэгийн үр нөлөө, уул уурхайгаас орон нутагт төвлөрөх орлого болон төрийн өмчит компаниудын худалдан авалтын талаарх мэдээлэлд “шумбаж” олж мэдсэн зүйлээ олон нийттэй хуваалцлаа.

Нээлттэй өгөгдлийг ашиглах нь орчин үеийн цахим технологийн хөгжилтэй уялдсан нийтийн удирдлагад нэвтэрч буй шинэ хандлага бөгөөд нийтийн мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг цоо шинэ түвшинд гаргаж сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлж төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нийтийн мэдээллийн үнэ цэнийг нээж бизнесийн салбарт болоод төрийн үйлчилгээнд инновацыг дэмжих хөшүүрэг болж байна. Иймээс сүүлийн жилүүдэд төрийн байгууллагуудаас ил болгосон их хэмжээний мэдээллийг боловсруулж, нэг стандартын дагуу цэвэрлэн нэгтгэх, харьцуулан хайлт хийх боломжтой байдлаар нийтэд хүргэхэд иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Эцэст нь тэмдэглэхэд бид энэхүү нэгэн сорилтот жилд 20 орчим хуулийн төсөлд санал шүүмж хүргүүлж, 80 гаруй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулан, судалгаа шинжилгээ, мониторинг, нийтийн өмгөөлөлд нийт 49 тэтгэлэг олгож, 70 гаруй хэвлэн нийтлэлийн бүтээгдэхүүн, 78 видео контент гаргажээ. Ийнхүү төлөвлөсөн ажлаа тасралтгүй явуулж, үр дүнг нь товчлон нэгтгэж Та бүхний гарт хүргэлээ. Хэрвээ танд энэхүү тайлан болон бидний үйл ажиллагаатай холбогдох санал байх аваас [osf@forum.mn](mailto:osf@forum.mn) хаягаар ирүүлээрэй. Бид таны саналыг таатай хүлээн авах болно.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал



(П.Эрдэнэжаргал)

# АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ

## АРДЧИЛЛЫН ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бид сонгуулийн үйл явц, улс төрийн намын санхүүжилт, төрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, энэ асуудлаарх гол хуулиудын хэрэгжилтийг иргэний нийгмийн оролцоотой эрчимжүүлэхэд анхааран ажиллаж байна.

2021 онд улс төрд өрнөсөн чухал үйл явдлын нэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль байв. УИХ-д суудал бүхий гурван намын нэр дэвшигчид өрсөлдсөн уг сонгууль нь 2019 онд Үндсэн хуульд туссан нэмэлт өөрчлөлтийн дагуу анх удаа зургаан жилийн хугацаагаар ажиллах Ерөнхийлөгчийг тодруулах байснаараа өмнөх сонгуулиудаас онцлогтой байлаа. 2021 оны 6 дугаар сарын 9-нд болсон уг сонгуульд нэрийн жагсаалтад бүртгэлтэй 2,041,985 сонгогчийн 59.35 хувь (1,210,628) оролцож саналаа өгсөн нь өмнөх Ерөнхийлөгчийн сонгуулиудтай харьцуулахад хамгийн бага ирц байв. Энэхүү ирцийн дүнд нэг талаас, засаглалын тогтолцоонд Ерөнхийлөгчийн институтын гүйцэтгэх үүргийн талаарх сонгогчдын мэдээлэл дутмаг, нөгөө талаас 15 хоног үргэлжилсэн сонгуулийн кампанит ажлын богино хугацаанд нэр дэвшигчид Монгол орны өргөн уудам нутаг дэвсгэрт тархан суурьшсан сонгогчдод хүрч ажиллахад хүндрэл үүссэн, мөн КОВИД-19 халдварын эрсдэл гэх мэт хүчин зүйл нөлөөлсөн байх талтай.

ННФ-ын зүгээс сонгогчдын боловсролд зориулж 2019 онд Үндсэн Хуульд туссан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрх, уг институтын засаглалын тогтолцоонд гүйцэтгэх үүргийн талаар эрдэмтэн судлаачдыг оролцуулсан цахим хэлэлцүүлгийг Бодлогод залуусын хяналт ТББ-тай хамтран 5 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулав. МУИС, МУБИС-ийн Үндсэн хуулийн эрх зүй, улс төр судлаач эрдэмтэд оролцсон дээрх хэлэлцүүлгийг Блуумберг ТВ, [www.gogo.mn](http://www.gogo.mn) зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэсэн билээ.

Түүнчлэн сонгогчдын боловсролыг дэмжих зорилгоор Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ-д ардчиллын үнэт зүйлсийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд чиглэсэн “Ардчиллын хамгаалагч” цахим аяныг зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлж ажиллав. Аяны хүрээнд “Санал чинь ямар үнэ цэнтэй вэ?”, “Ерөнхийлөгч гэж хэн бэ?” буюу “Одоо хэнийг сонгох гээд байгаа билээ?” иргэний оролцооны асуудлаар “Одоо тэгээд яах юм бэ?” гарчиг бүхий 19 видео, 15 зурагт хуудсыг нийгмийн сүлжээгээр #сонгуульмонгууль түлхүүр үг ашиглан түгээв. Дээрх мэдээллийг нийгмийн сүлжээгээр үзсэн хандалтын тоо 147,428 хүрчээ.





### СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛД:

*Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрх сэдвийн хүрээнд судлаач Н.Соёл-Эрдэнэ, МУБИС-ийн багш, улс төр судлаач Э.Гэрэлт-Од, Хууль зүйн ухааны доктор, профессор О.Мөнхсайхан нар сэтгүүлч О.Ариунгэрэлийн чиглүүлснээр Ерөнхийлөгч зөвхөн бэлэг тэмдэг төдий албан тушаалтан уу эсвэл хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд болоод улс төрийн хүчний тэнцвэрийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг институт үү гэх зэрэг асуултуудад хариулт өгч ярилцлаа. 2021.05.29.*

Өнгөрсөн хугацаанд бид ардчиллын гол үйл явц болох сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгох, аливаа зөрчил гарахаас сэргийлэх, улмаар сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн хяналт, оролцоог тасралтгүй дэмжин хамтарч ажилласаар ирсэн. 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд сайн дурын залуусыг оролцуулан ажиглалт хийх, сонгуулийн санхүүжилт, сонгогчдын нэрийн жагсаалт, автоматжуулсан системийн ажиллагаа, сонгуулийн үеэрх нийтийн

сүлжээний болон хэвлэл мэдээллийн мониторинг хийж гүйцэтгэхэд “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн байгууллагуудад дэмжлэг үзүүлж хамтран ажиллав.

Сонгуулийн процессыг тодорхой аргачлалын дагуу тасралтгүй ажиглаж үр дүнг олон нийтэд шуурхай танилцуулах нь сонгуулийн үйл явцтай холбоотой маргаан зөрчлөөс сэргийлэхэд чухал нөлөөтэй байдаг. Санал хураах үйл явц хуулийн дагуу явагдсан ч зохион байгуулалтын алдаанаас үүдэлтэй хардлага, маргаан нь зарим нөхцөлд сонгуулийн үр дүнд итгэх олон нийтийн итгэлийг бууруулж, улмаар ноцтой үр дагаварт хүргэх эрсдэлтэйг гадаад, дотоодын олон жишээнээс харж болно.

Иймээс бид энэ жилийн Ерөнхийлөгчийн сонгуулийн процессыг ажиглахад “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн Бодлогод

залуусын хяналт ТББ-д дэмжлэг үзүүлж ажиллалаа. Сонгуулийн өдөр тус байгууллага Улаанбаатар хотын 48, Баянхонгор, Дархан-Уул, Төв, Увс аймгийн таван хэсгийн хороонд 107 сайн дурын ажиглагч ажиллуулан санал хураах, тоолох, дүн гаргах үйл явцад тасралтгүй хяналт тавих ажлыг удирдан зохион байгуулав. Үүнээс

гадна иргэний нийгмийн ажиглагчид БНСУ-ын Сөүл, Япон Улсын Токио, АНУ-ын Нью-Йорк хотуудад санал хураах байруудад ажиллажээ. Бодлогод залуусын хяналт ТББ-ын зүгээс сонгуулийн 120 ажиглагчдад арга зүйн сургалтыг цахимаар зохион байгууллаа.



Бодлогод залуусын хяналт ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга Т.Энхжаргал Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар гадаадад ажиллаж амьдарч буй иргэдийн өгсөн саналыг тоолох үйл явцад ажиглалт хийж байгаа нь



**Enkhjargal Tumenjargal is at Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо.**

2m · Ulaanbaatar · 🌐

Гадаад улсад байгаа иргэдээс авсан саналыг тоолох ажиллагааны бэлтгэл хангагдаж байна. 22 цагаас нийт 5618 сонгогчийн саналыг санал тоолох төхөөрөмжинд уншуулах, түүний дараагаар хяналтын тооллогыг гараар тоолох үйл явц эхэлнэ.

[Шударга сонгуулийн төлөө Иргэний нийгмийн хяналт](#)  
[Бодлогод залуусын хяналт ТББ](#)



Сонгуулийн ажиглалтад залуусыг татан оролцуулах нь тэдэнд сонгуулийн хууль тогтоомж, чөлөөт шударга сонгуулийн олон улсын стандартуудыг танилцуулж,

ардчилсан улсын иргэний хувьд улс төрийн чухал үйл явцад идэвхтэй оролцох, сонгогчийн боловсролыг нэмэгдүүлэх давхар ач холбогдолтой юм.



2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцад хийсэн мониторинг, ажиглалтын урьдчилсан дүнг танилцуулах хэвлэлийн хуралд сэтгүүлчдээс гадна Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институц, хүний эрхийн албаны олон улсын ажиглагчид оролцон мэдээлэл авч байгаа нь



**2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчийн нэрийн жагсаалтад МИДАС ТББ-ын хийсэн мониторингийн тайлангаас:**

2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар гадаадад оршин сууж буй иргэдэд сонгох эрхээ эдлэх боломж олгон, сонгуульд оролцуулсан нь сайшаалтай. Гэвч сонгуульд хяналт тавьж ажилласан иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлэлд дурдсанаар гадаадад байгаа сонгуулийн насны 122,000 иргэнээс 7,394 сонгогч буюу 6.6 хувь нь сонгуульд санал өгөхөөр бүртгүүлсэн ба тэдний 75 хувь нь (5,618 сонгогч) санал өгчээ. Энэ нь гадаадад байгаа нийт сонгогчийн дөнгөж 4.6 хувьтай тэнцэж байна. Иймд цаашид гадаадад байгаа сонгогчдыг бүртгэх үйл явцыг тодорхой, хүртээмжтэй болгох, санал авах хугацааг уртасгах, санал хураалтыг иргэдэд ээлтэйгээр зохион байгуулах шаардлагатайг тэмдэглэсэн байна. Тухайлбал:

- Гадаадад байгаа иргэдийн саналыг авахдаа зөвхөн дипломат төлөөлөгч бүхий байрлалд бус монгол иргэд олноороо оршин суудаг төвлөрөл нягт газруудыг түшиглэн зохион байгуулах;
- Шуудангийн үйлчилгээ нь найдвартай газруудад баталгаат шуудан ашиглах боломжийг судалж, нэвтрүүлэх;
- Цахим хэлбэрээр санал авах боломжийг судалж, гарах эрсдэлээс урьдчилан сэргийлж бүртгэлийг нарийвчлахыг зөвлөжээ.

Иргэний нийгмийн зүгээс сонгуулийн үйл явцад тавих хяналт нь зөвхөн сонгуулийн өдрийн үйл явцыг ажиглахаар хязгаарлагдахгүй өөр хоорондоо уялдаатай цогц үйл ажиллагаа байдаг. Тухайлбал, шударга сонгуулийн нэг гол зарчим болох өрсөлдөөний тэгш гараа хэрхэн хангагдаж буйд хяналт тавихад Сүлжээний гишүүн Глоб Интернэшнл төв ТББ “Хэвлэл мэдээллийн мониторинг”; Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв “Нийгмийн сүлжээн дэх сонгуулийн сурталчилгааны мониторинг”-ийг тус тус хийж гүйцэтгэлээ. Мөн санал хураахтай холбоотой аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонгууль тэгш байх зарчим буюу “нэг сонгогч-нэг санал өгөх” зарчмыг хангах байдалд МИДАС ТББ хяналт тавьж ажиллалаа. Энэ хүрээнд тус байгууллага “Сонгуулийн автоматжуулсан системийн мониторинг,” “Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг”-ийг хариуцан ажиллав.

Өмнөх хэд хэдэн сонгуулиар сонгогчдыг таних гол хэрэгсэл болох био өгөгдлийн давхардал, хуурамч хаягийн бүртгэл, бүртгүүлсэн хаягтаа оршин суудаггүй олон хүнийг бүртгэсэн байх гэх мэт асуудал гарсныг янз бүрийн эх сурвалжаар мэдээлж байсан билээ. Эдгээр алдаа дутагдлыг сонгуулийн хууль тогтоомжид тусгаснаар сонгогчдын нэрийн жагсаалтын хуулбарыг нам, эвсэлд цахим хэлбэрээр олгодог болсон ч сонгуульд хөндлөнгийн хяналт тавьж буй иргэний нийгмийн байгууллагуудад зөвхөн цаасан хувилбартай танилцах боломж олгохоор зохицуулсан байдаг. Үүнтэй холбоотойгоор иргэний нийгмийн зүгээс сонгогчдын нэрийн жагсаалтад өргөн хүрээнд хяналт тавих бололцоо хязгаарлагдмал байсаар ирсэн юм. Нам, эвслүүдийн хувьд хуулиар олгогдсон боломжоо ашиглан сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавьсан удаа байхгүй. Иймд иргэний нийгмийн зүгээс нөөц бололцоогоо дайчлан



**2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвийн хариуцан гүйцэтгэсэн Нийгмийн сүлжээн дэх сонгуулийн сурталчилгааны мониторингийн тайлангаас:**

Мониторингийн тайланд энэхүү харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой хэд хэдэн зөвлөмж санал болгосны дотор Монгол Улсад цахим орчныг зохицуулахдаа хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байхад онцгой анхаарч, дараах шалгуураар хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэжээ.<sup>1</sup> Үүнд:

- Цахим орчинд аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хэрэглэгчдэд зориулсан мэдлэг олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг хууль тогтоомжийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгох;
- Цахим орчинд эрх нь зөрчигдсөн буюу тийнхүү зөрчигдөх бодит эрсдэлтэй хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч, шалган шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгох;
- Цахим орчин дахь илт хууль бус агуулгыг хэт өргөн хүрээнд бус, тодорхой, хоёрдмол утгагүйгээр нэг мөр ойлгож хэрэглэх байдлаар тусгайлан тодорхойлох;
- Цахим орчин дахь илт хууль бус агуулгыг арилгах, тийм агуулгаас сэргийлэх нь хүний эрх, эрх чөлөөг зөрчих нөхцөл болох ёсгүйг онцгойлон анхаарч зохицуулах;
- “Терроризмтой тэмцэх”, “үндэсний аюулгүй байдлыг хангах” хүрээнд хууль бус болон зохих үндэслэлгүйгээр хэвлэлийн эрх чөлөөг цагдан хянах, иргэдийн захидал харилцааг хэт мөрдөн тагнахгүй байх, мэдээллийг шифрлэх технологийг ямар нэг байдлаар хязгаарлахгүй байх нөхцөлийг заавал тусгах.

<sup>1</sup> Глоб Интернэшнл төв, Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт (Судалгаа), 2019. [https://www.gic.mn/public/docs/publications/survey\\_result\\_social\\_media\\_regulation\\_191024.pdf](https://www.gic.mn/public/docs/publications/survey_result_social_media_regulation_191024.pdf)



тодорхой хүрээнд хяналт тавих нь зүйтэй гэж үзэн хамгийн олон сонгогчтой Баянзүрх дүүргийн 28 дугаар хорооны сонгуулийн 103 хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавих ажлыг ННФ-ын дэмжлэгтэйгээр МИДАС ТББ хийж гүйцэтгэв.

Тус байгууллага нь 2020 оны УИХ-ын сонгуулийн явцад мөн сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавьж ажилласан бөгөөд мониторингийн үр дүнд үндэслэн УБЕГ-т хүргүүлсэн зарим зөвлөмжийг холбогдох хууль тогтоомж, журамд тусган хэрэгжүүлснийг дурдах нь зүйтэй. Үүнд:


- Иргэд [election.burtgel.gov.mn](http://election.burtgel.gov.mn) вэб хуудас ашиглан өөрийн хаягт бүртгэлтэй бусад сонгогчийн мэдээллийг баталгаажуулж шалгах боломжтой болсон;
- Ирцийн мэдээллийн насны ангиллыг нарийвчилсан;
- Сонгуулийн өдөр хурууны хээ уншаагүй иргэнийг бүртгэхдээ регистрийн дугаарыг түлгехаас гадна зургийг нь авах болсон;
- Сонгогчдын ирцийн мэдээг шуурхай дамжуулах систем нэвтрүүлсэн.

Цаашид сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгоход анхаарах асуудлууд оршсоор байгааг иргэний нийгмийн мониторингийн үр дүн харуулж буй бөгөөд ННФ-ын зүгээс үүнд анхаарал хандуулж, энэ чиглэлээр мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагууд болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллах болно.

Бид улс төрийн санхүүжилт, түүний нэг бүрэлдэхүүн хэсэг болох сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах чиглэлээр сүүлийн жилүүдэд нэлээд ажил санаачлан хэрэгжүүлж ирлээ. Энэ хүрээнд сонгуулийн

санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд гадаад, дотоодын судлаачид, иргэний нийгэм болон бусад талыг оролцуулан шургуу ажилласан. Улмаар сонгуулийн тухай хууль тогтоомжид сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад чиглэсэн зарим нааштай өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах, хяналт тавихад иргэний нийгмийн байгууллагууд, судлаачид болон төрийн холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. 2021 онд сонгуулийн санхүүжилтэд хяналт тавихад гол үүрэгтэй Төрийн Аудитын байгууллагад сонгуулийн зардлын тайланг хүлээн авах, хяналт тавих цахим систем хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа. Системийн хөгжүүлэлтийг "Ухаалаг засаглал" ТББ хариуцан гүйцэтгэсэн ба уг систем нь нам, эвсэл, иргэний хандивын мэдээллийг оруулах, холбогдох журмын дагуу тайлан гаргах, аудитын хуулийн этгээд тухайн тайланг баталгаажуулах, Үндэсний аудитын газраас тайланг баталгаажуулах гэсэн гурван үндсэн модультай. Улмаар системийн тусламжтайгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль, 2021 онд болж өнгөрсөн УИХ-ын 18, 28 дугаар тойргийн нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайланг хүлээн авч олон нийтэд шуурхай нээлттэй, ил тод мэдээлэхэд ашиглалаа.

2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд ажиглалт хийсэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, Хүний эрхийн газрын тайланд дээрх системийн талаар дурдаж сайшаасныг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь Монгол Улс сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгох чиглэлд бүс нутагтаа үлгэр жишээ болохуйц ахиц дэвшил гаргаж буйн нэг жишээ болох нь дамжиггүй юм.



МИДАС ТББ-ын  
гүйцэтгэх захирал  
С.Энхжаргал  
сонгогчдын нэрийн  
жагсаалтад хийсэн  
мониторингийн  
дүнг танилцуулж  
байгаа нь



**2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад мониторинг хийсэн МИДАС ТББ-ын тайлангаас:**

Мониторингийн хүрээнд Баянзүрх дүүргийн 28-р тойргийн 103 хэсгийн хороонд ажиллахад 21 нь хамтран ажиллахаас татгалзсан ба сонгогчдын нэрийн жагсаалттай танилцуулсан ч шаардлагатай тэмдэглэл хөтлүүлэхээс татгалзсан буюу мэдээлэл авах боломжийг хаах гэх мэтээр нэрийн жагсаалтад хяналт тавих бололцоог хязгаарласан. Эдгээр хүчин зүйлийн улмаас нийт 82 хэсгийн хорооны 202,415 сонгогчийн нэрийн жагсаалттай танилцаж мэдээллийг нягтлав. Уг нэрийн жагсаалтаас хяналтын хүрээнд хаягаар очиж тулгалт хийж, мэдээллийг түүвэрлэхдээ дараах шалгуурыг үндэслэв:

- Нэг хаяг дээр олон хүн (зургаагаас дээш) бүртгэлтэй байгаа эсэх;
- Ижил овог, ижил нэртэй хүн нэг хаяг дээр бичигдсэн эсэх;
- Овог, нэр ижил, регистрийн дугаар ижил эсвэл ойролцоо хүмүүс ойролцоо хаяг дээр байгаа эсэх;
- Овог, нэр өөр олон хүн нэг хаяг дээр байгаа эсэх;
- “Түр хасав” төлөвийн тоо нэг хаяг дээр олон байгаа эсэх.

Дээрх шалгуурын дагуу нийт 82 хэсгийн хорооны 202,415 сонгогчийн мэдээллээс 1,229 иргэний мэдээллийг түүвэрлэн авч хаягаар нь очиж баталгаажуулалт хийхэд дараах дүр зураг харагдлаа.



Дээрх мэдээллээс анхаарал татаж буй нь тодорхой хаяг дээр бүртгэлтэй 129 сонгогчийг тухайн хаяг дээр оршин суугчид нь огт мэдэхгүй буюу илүү бүртгэлтэй хүмүүс байв.

## УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд туссан нэмэлт, өөрчлөлтөд улс төрийн намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байна, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно гэж заасан. Улс төрийн намын төлөвшлийг дэмжих болон тогтолцооны хөгжлийг нь хангахад чиглэсэн дээрх өөрчлөлтийг тусган Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх ажлыг УИХ-аас эхлүүлсээр багагүй хугацаа өнгөрлөө. ННФ-ын зүгээс улс төрийн санхүүжилтийг зохицуулж буй харилцааг боловсронгуй болгоход түлхүү анхаарч цуврал судалгаа шинжилгээ хийхийн зэрэгцээ бодлогын чухал асуудлуудаар оролцогч талуудын дунд хэлэлцүүлгүүд тасралтгүй зохион байгуулсаар ирлээ.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлд зайлшгүй анхаарвал зохих чухал сэдвүүдийг хөндсөн, олон

улсын чиг хандлага, дотоодод улс төрийн намуудад тулгарч буй бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга замуудыг хэлэлцсэн цуврал нэвтрүүлгийг эрх зүйчид, улс төр судлаач эрдэмтдийг оролцуулан бэлтгэж олон нийтийн хүртээл болголоо. Эдгээр нэвтрүүлгээр ардчилсан тогтолцоонд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг, гишүүнчлэл, эвлэлдэн нэгдэх эрх, ардчиллын чухал институт болохын хувьд хүлээх хариуцлагын тэнцвэртэй зохицуулалт, бодлогын намыг төлөвшүүлэх асуудал болон бүтэц, төрийн санхүүжилтийг хуваарилах аргачлал, хяналт зэрэг асуудлуудыг хэлэлцлээ. Түүнчлэн улс төрийн намуудад төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд ямар босго болон шалгуурыг баримтлах нь зүйтэй талаар тодорхой зөвлөмж боловсруулах судалгааг улс төр судлаач Э. Гэрэлт-Од, Ц.Бүжидмаа нар хийж гүйцэтгэв.



Сэтгүүлч Б. Оюунчимэг намын хатуу гишүүнчлэл, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудлаар ШУТИС-ийн багш, улс төр судлаач Я. Төгөлдөр, МУИС-ийн багш, улс төр судлаач Д. Бумдарь нартай ярилцаж байгаа нь

Ийнхүү олон талын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлснээс гадна УИХ-ын хуулийн төсөл боловсруулах дэд Ажлын хэсгийн боловсруулсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын эхний төслийг Англи хэлнээ хөрвүүлэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, Хүний эрхийн газар, Европын Зөвлөлийн Венецийн комисс болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс санал шүүмж авахад нь техникийн туслалцаа үзүүлэв.

Бид цаашид улс төрийн намын хуулийг шинэчлэх асуудалд намуудын төлөөлөл, эрдэмтэд, иргэний нийгмийнхний идэвхтэй оролцоог ханган хэлэлцүүлэг өрнүүлж, маргаан дагуулсан асуудлаар оновчтой шийдлүүд боловсруулах, зөвшилцөл бий болгоход хувь нэмэр оруулах бусад үйл ажиллагааг шат дараалалтай зохион байгуулахаар төлөвлөж байна.

## ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Өнгөрсөн онд төрийн мэдээллийн ил тод байдал, төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог зохицуулсан эрх зүйн орчинд томоохон өөрчлөлтүүд орлоо.

Төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд чухал нөлөө бүхий 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг орлох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг УИХ-аас 2021 оны 12 дугаар сард хэлэлцэн батлав. ННФ-ын зүгээс дээрх хууль болон мэдээллийн орчныг зохицуулахтай холбоотой Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль боловсруулах шатанд шаардлагатай судалгаа шинжилгээг хийх, хуулийн төсөл боловсруулагчдад иргэний нийгмийн саналыг нэгтгэн зөвлөмж байдлаар хүргүүлэх, олон улсын болон дотоодын судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг санаачлан хийв. Тухайлбал, дээрх хуулиудын төслийг олон улсын холбогдох эрх зүйн баримт бичигт туссан стандартууд, сайн туршлагатай харьцуулан үнэлж, зөвлөмж боловсруулахад Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв (АТБХОУТ) –ийн эрх зүйчидтэй хамтран ажилласан ба тус байгууллагатай хамтарсан цахим хэлэлцүүлгийг 2021 оны 4 дүгээр

сарын 23-ны өдөр зохион байгуулан иргэний нийгмийн байгууллагууд, бусад холбогдох талд мэдээлэл өгөв. АТБХОУТ нь иргэний нийгмийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дэлхийн 100 гаруй оронд техникийн туслалцаа, судалгаа шинжилгээ, боловсролын дэмжлэг үзүүлж ирсэн өндөр нэр хүнд, туршлага бүхий олон улсын байгууллага юм.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн тухайд иргэний нийгмийн зүгээс нэлээд шүүмжлэл дагуулсан зохицуулалт нь нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох, ашиглах харилцааг зохицуулсан хэсэг байв. Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгоход нээлттэй формат буюу ямар нэг саад бэрхшээлгүй, өндөр үнэ төлбөргүйгээр хуулан боловсруулж, ашиглах бололцоо бүрдүүлэхийн сацуу аливаа зорилгоор ашиглахад хяналт тавьж хязгаарлахгүй байх гэх мэт олон улсад мөрдөж буй зарчмуудыг бүрэн тусгаагүйг шүүмжид онцолж байв.

Монголын Улсын иргэний нийгмийн байгууллагуудын хувьд нээлттэй мэдээллээр дамжуулан төрийн үйл ажиллагаанд иргэдийн зүгээс хяналт тавих, хариуцлагыг нэмэгдүүлэхэд технологийн хөгжлийг ашиглах, орчин үеийн өгөгдөл боловсруулах аргуудыг ашиглахад сүүлийн жилүүдэд чамлахааргүй ахиц дэвшил гарч буй



бөгөөд ННФ ч энэ чиглэлийн чадавхыг бэхжүүлэхэд мөн анхаарч дэмжлэг үзүүлж ирсэн юм. Энэ хүрээнд Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан Бодлогод залуусын хяналт ТББ, Авлигатай тэмцэх газартай хамтран “Дата эрх чөлөө: Мэдэх эрх” үзэсгэлэнг 2021

оны 12 дугаар сарын 6-10-нд зохион байгуулав (<https://ikon.mn/n/2ehe>). Үзэсгэлэнд тавигдсан өгөгдлийг боловсруулахад Тунгаахуй өгөгдлийн урлан ТББ-ын шинжээчид дэмжлэг үзүүлж ажиллалаа.



Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, комиссар Д.Дуламсүрэн “Дата эрх чөлөө: Мэдэх эрх” үзэсгэлэнг нээж үг хэлж буй нь, 2021.12.06-10.

Энэхүү үзэсгэлэнд дээрх байгууллагуудаас гадна нийтийн мэдээллийг харьцуулалт хийх боломжтой өгөгдөл болгон олон нийтэд хүргэх, төрийн хариуцлага, хяналттай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж буй дараах байгууллагууд мөн оролцсон юм. Үүнд:

- Лийд төгсөгчдийн холбоо ТББ-аас 2020, 2021 оны сонгуулиар сонгогчдын ирцийн мэдээг нарийвчилж, цахим хяналт тавьсан түүх, дата дүрслэлээ танилцуулав.
- Монголын дата клубээс төрийн өмчит уул уурхайн компаниудын шилэн данс болон улс төрчдийн холбоо хамаарлыг харуулсан түүх, дата дүрслэл толилуулав.
- Ikon.mn сайт ЖДҮСан, боловсролын зээлийн сан зэрэг хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа түүхийг танилцуулав.
- Цогц хөгжлийн төв ТББ-аас УИХ-ын гишүүд, сонгуулийн амлалтыг хянах зорилготой uih.mn,

- сонгуулийн музей зэрэг төслүүдээ дэлгэн харуулав.
- Залуусын давлагаа клубээс гэр хороололд амьдарч буй залуусын өөрчлөлт авчирч буй жишээ түүхийг хуваалцав.
- БЗХ ТББ-аас УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын мониторинг, үйл ажиллагааг харуулсан зардлын ил тод байдал, УИХ-ын гишүүдийн ХОМ-ын холбоо хамаарлыг харуулсан дата дүрслэлийг бэлтгэн танилцуулав.
- АТГ-аас ХОМ-д хяналт тавьж буй, авлигын хор үршгийг барагдуулж буй талаарх тоо баримтын талаарх өгөгдлийг танилцуулав.

2019 онд Үндсэн хуульд туссан төрийн хариуцлагатай үйл ажиллагааг дэмжих, үүнд ард түмнийг төлөөлөх институт болох парламентын хяналтын чиг үүргийг бэхжүүлэхэд чиглэсэн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2021 онд УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчилсэн ба УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийг шинээр баталсан. Парламентад нэг нам давамгайлсан нөхцөлд парламент дахь цөөнхийн хяналт, оролцоо нэн чухал тул энэ асуудлаарх олон улсын туршлагыг харьцуулан судлах, цөөнхийн эрх, үүргийг зохицуулах эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмж боловсруулахад Бодлогын Инновацийн Хүрээлэн ТББ-д дэмжлэг үзүүлэв.

ННФ-аас дэмжин нийтийн эрх ашгийн өмгөөллийн чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны хүрээнд 2021 онд буруутай шийдвэр, эс үйлдэхүй нь нийтийн эрх ашгийг хохироосон төрийн байгууллага, албан тушаалтнуудыг хариуцагчаар татсан хэд хэдэн хэрэг нааштай шийдэгдээд байна.

Тухайлбал: Фединтас партнерс ХХН “КОВИД-19 цар тахлын үед хандив тусламжийн зарцуулалтын ил тод байдал, хариуцлагыг сайжруулах” нь төслийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн онцгой байдлын газар, Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин

судлалын үндэсний төвийн Шилэн дансны цахим хуудас дахь хандив тусламжийн мэдээллийн ил тод байдалд дүн шинжилгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, гэм буруутай албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаад байна. Тэдний гаргасан гомдлын дагуу Үндэсний аудитын газар дээрх байгууллагуудад нийцлийн аудит хийж, 2020 онд иргэд, аж ахуйн нэгжүүдээс цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан хандивласан мөнгөн болон материаллаг тусламжийн орлого, зарцуулалтын мэдээг Шилэн дансны цахим хуудсандаа бүрэн мэдээлээгүй болохыг тогтоон, зөрчлөө арилгах үүрэг зөвлөмж өгчээ.

Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо (МХБИБҮХ) ТББ нь ердийн өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон 80,000 гаруй иргэнийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлүүлж чаджээ. 2019 онд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орлогын албан татвараас чөлөөлөгдөх нөхцөл бүрдсэн ч хуулийн хэрэгжилтийг хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэхэд мөрдөх нарийвчилсан журам батлахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарах дээрх татварын чөлөөлөлтийг ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан хувь хүнд хамаарахгүй байхаар заажээ. Үүний улмаас ердийн өвчний улмаас хараа, сонсгол, тулах, хөдлөх эрхтний болон оюун, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэд хуулиар олгогдсон боломжийг эдэлж чадахгүй болоод байв. Иймд МХБИБҮХ нь дээрх иргэдийг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган, хоёр ч шатны шүүх хуралдаанд оролцоноор 2019 онд Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам”-ын 2.4 дэх заалтыг хүчингүй болгуулж чаджээ.

Тэрчлэн МХБИБҮХ нь энэ онд төрийн байгууллагуудын мэдээлэл, цахим үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох төслийг ННФ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Төр мэдээлэл харилцаа, холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх үүргийг хуулиар хүлээсэн байдаг ч энэ үүрэг амьдралд хэрэгждэггүй. Харилцаа холбоо, мэдээлэл, технологийн газраас баталсан “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хүртээмжтэй болгох талаар дурдаагүй байна. Иймд төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг хангаж, холбогдох зардлыг шийдвэрлүүлэх талаар нэхэмжлэл гаргаад байна.

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр мэргэшин орон нутагт түүштай үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих хүрээнд Амьд хууль ТББ-д нийтийн эрх ашгийн өмгөөллийн хөтөлбөр хөгжүүлэх тэтгэлэг олголоо. Амьд хууль ТББ нь төрийн өмчийг хууль бусаар захиран зарцуулсан, мөн төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халсны улмаас төсөвт хохирол учруулсан зэрэг асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гарган амжилттай шийдүүлж байсан юм. Тус байгууллага нь 2021 онд олгогдсон тэтгэлгийн хүрээнд нийтийн өмчийг хамгаалах үйл ажиллагаа явуулахаас гадна цаашид энэ чиглэлээр тогтвортой, үр нөлөөтэй ажиллах нөөц боломж, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх юм.

## ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ НЬ

Нээлттэй Нийгэм Форум нь ардчилсан сайн засаглал, хүний эрхийн хэрэгжилтийг хянах, шаардахад иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хэрэглэж ашиглахуйц мэдлэг, мэдээллийг хангах зорилгоор "Иргэний нийгмийн орон зай" хөтөлбөр эхлүүлээ. Шинэ хөтөлбөрийн эхний жилд бид иргэд, иргэний нийгмийн

оролцоог дэмжих чиглэлд иргэдийн улс төр, иргэний боловсролыг нэмэгдүүлэхэд анхаарахын зэрэгцээ иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, нийгэмд үзүүлж буй үр нөлөөг олон нийтэд мэдээлэх суваг бий болгох туршилтын ажлууд хийлээ.

### ОЛОН НИЙТИЙН УЛС ТӨРИЙН БОЛОН СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

Иргэдийн улс төр, сонгуулийн боловсролыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд мэдлэг туршлагатай иргэний нийгмийн байгууллага, мөн ихдээд сургуулийн эрдэмтэн судлаачдыг татан оролцуулж, сонгогчийн боловсролын шинэлэг агуулгыг түршиж ажиллалаа. Өмнөх жилүүдийн туршлагаас харахад УИХ болон орон нутгийн ИТХ-ын сонгуулийн дараа сонгогчийн идэвх буурах хандлага Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр ажиглагддаг тул сонгогчдын идэвхийг дэмжих үйл ажиллагаа чухал болж ирдэг. Нөгөө талаас, цөөн тооны нэр дэвшигчтэй Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нэгдсэн агуулгатай иргэний боловсролын үйл ажиллагаа хэрэгжүүлэх, шинэлэг хэлбэрийн агуулга, арга зүйг түрших боломж гардаг юм.

Бид сонгогчийн боловсролын уламжлалт агуулгыг иргэдийн улс төрийн боловсрол, орчин цагийн иргэний боловсролын агуулгаар баяжуулах стратегийг боловсруулан кампанит ажил төлөвлөж, уг үйл ажиллагааны агуулгыг арвин туршлага, мэргэжлийн чадавхтай Сонгогчдын боловсрол төв ТББ хөгжүүлэн, 2021 оны дөрвөөс зургадугаар сард мэдээллийн аян хэлбэрээр амжилттай хэрэгжүүлэв. Ерөнхийлөгчийн сонгуулийн циклтэй уялдуулан (i) сонгогчийг идэвхжүүлэх; (ii) иргэд сонгуульд хариуцлагатай хандахад туслах мэдлэгээр хангах; (iii) саналаа өгөхөд уриалах гэсэн зорилтын хүрээнд цувралаар мэдээллийн гурван аян өрнүүлээ.

Уг мэдээллийн аянд дараах арга хэмжээ багтав. Үүнд:

- Ардчилсан сонгуулийн ач холбогдол, Ерөнхийлөгчийн институт, Ерөнхийлөгчийн сонгуулийн үе шатуудыг тайлбарласан агуулга бүхий “Би сонгуульд мэдлэг мэдээлэлтэй оролцож, хариуцлагатай сонгогч байна” аян;
- Сонгууль нь төр барих эрхийг сонгогчдоос шилжүүлж авахын төлөөх улс төрийн намуудын өрсөлдөөн болох тухай, намууд мөрийн хөтөлбөр дэвшүүлж өрсөлддөг бөгөөд энэ нь хэрэгжүүлэхээр амлаж буй бодлого болох тухай, мөрийн хөтөлбөрийг судлахын ач холбогдол, сонгуулийн үхүүлга сурталчилгаанд хориглосон үйл ажиллагааг таниулах, мөн мэдээллийн боловсрол олгоход чиглэсэн “Би хариуцлагатай улс төрчийг Ерөнхийлөгчөөр сонгоно” аян;
- “Би саналаа өгнө”/“Би саналаа өгсөн” цахим давлагаа зэрэг болно.

Төслийн хүрээнд Сонгогчдын боловсрол төв ТББ нь 40 орчим агуулгыг видео, аудио, комикс, гар зураг, хэвлэмэл зэрэг хэлбэрт оруулан 102 бүтээгдэхүүн бэлтгэн, цахим сүлжээ, олон нийтийн үйлчилгээний газар байршуулан сонгогчдод түгээжээ. Цар тахлын нөхцөл байдлын улмаас нийт бүтээгдэхүүний 95 орчим хувь нь цахим сүлжээгээр дамжиж олон нийтэд хүрсэн байна. Давхардсан тоогоор сонгуулийн насны 765,000



орчим иргэн цахимаар мэдээлэл хүлээн авснаас видео контентыг 186,000, цахим аудио постерыг 257,000, комикс зургийг 147,000, телевизийн нэвтрүүлэг болон

подкастыг 5,600, олонд танигдсан экспертүүдийн хөрөгт эшлэл бүхий цахим постерыг 95,000, хэвлэмэл материалыг 3,900 орчим хүн тус тус үзэж сонирхжээ.




Аяны хүрээнд гарсан зарим постер, 2021 оны 4-6 дугаар сар.

Засаглалын институцуудын тухай цэгцтэй мэдлэг бий болгох зорилгоор институцийн ардчилсан сайн засаглалд гүйцэтгэх чиг үүрэг, хуулиар түүнд олгосон эрх мэдлийг танилцуулсан цуврал тайлан гаргахаар ажиллаж байна. “Ерөнхийлөгч, түүний чиг үүргийн талаар сонгогчийн мэдэх ёстой зүйлс” тайлан нь энэхүү

цувралын эхнийх нь бөгөөд дараагийн ээлжид УИХ, Засгийн газар, шүүх, хууль сахиулах тогтолцоо, төрийн аудит, улс төрийн намууд, сонгуулийн менежментийн төв байгууллага, авлигатай тэмцэх байгууллага зэрэг институцийг авч үзсэн тайлангууд гарах юм.

Энэхүү гарын авлагад

- Ерөнхийлөгчийн тогтолцооны сонгодог болон холимог хэлбэрийн тухай онолын тойм, Ерөнхийлөгчийн институцийн тухай ойлголт;
- Төрийн эрх мэдлийн хуваарилалтад Ерөнхийлөгчийн институцийн эзэлж буй орон зай, Үндсэн хуулиар баталгаажуулсан бүрэн эрхүүд;
- Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн Мөрийн хөтөлбөрөөр дамжуулан Ерөнхийлөгч ард түмнийг төлөөлөх мандатыг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага зэргийг багтаасан болно.



## ШИНЭ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ

Иргэний нийгмийн байгууллагууд, тэр дундаа ННФ нь бодлогын олон чухал асуудлаар салбарын мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах, маргаантай асуудлаар талуудын байр суурийн үндэслэлийг тайлбарлах, бодлогын тулгамдсан асуудлаар шийдэл санал болгох зэрэг зорилгоор олон арван судалгаа хийж, үр дүнг нь тайлан болгон хэвлүүлдэг билээ. Гэхдээ эдгээр судалгааны тайлан нь мэргэжилтнүүдэд зориулагдсан тул тухайн салбарын мэргэжлийн үг хэллэг, хэл найруулгыг тусгасан, техникийн бичвэртэй тул олон нийтэд бүрэн дүүрэн хүрдэггүй тал бий. Тиймээс тус хөтөлбөрөөс шинэ судалгааны үр дүнг олон нийтэд хүргэх ажлыг эрчимжүүлэхэд анхаарч байна.

Бодлогын судалгааны үр дүнг олон нийтэд хүргэх чиглэлд бид 2021 онд хоёр байгууллагатай хамтран хоёр стратегийг туршин ажиллаж байна. Уламжлал болоод байгаа бодлогын судалгаанд суурилсан олон талын оролцоот хэлэлцүүлгийн арга нь тухайн асуудлыг

сонирхдог, энэ чиглэлээр ажилладаг, ашиг сонирхол нь хөндөгдсөн хүмүүсийг оролцуулан, тал талаас шүүн хэлэлцэх явцдаа мэдлэг мэдээлэл хүргэхэд үр нөлөөтэй арга юм. 2021 онд “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн эвсэлтэй хамтран боловсролын салбарын тэгш байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн цуврал бодлогын судалгаанд суурилсан хэлэлцүүлэг зохион байгуулав. Таван судалгаанаас бүрдэх уг цувралын эхний гурав болох хос хэлний боловсрол, жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн охид, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаарх хэлэлцүүлгийг 2021 онд хийж, 2022 онд орлого багатай өрхийн хүүхэд, малчин өрхийн хүүхдийн боловсролыг бодлогоор дэмжих асуудлаарх судалгааг хэлэлцүүлэх юм. Судалгаануудын дүгнэлт, бодлогын зөвлөмжийг салбарын шийдвэр гаргагчдад хүргэж, боловсролын бодлогод тусгахад чиглэсэн нөлөөллийн ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа болно.



Судлаач С.Асланбек “Үндэсний цөөнх иргэдийн эх хэлээрээ суралцах эрх болон тэгш хамруулах боловсрол” сэдвээр гүйцэтгэсэн бодлогын судалгаагаа хэлэлцүүлэв. 2021.11.19.



Судлаач Ж.Содномдаржаа цахим хэлэлцүүлэгт “Жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн охидыг боловсролд тэгш хамруулах нь” бодлогын судалгаагаа танилцуулав. 2021.11.23.



Судлаач Н.Батзоригийн гүйцэтгэсэн “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол” сэдэвт бодлогын судалгааны хэлэлцүүлгийн нээлт, 2021.12.02.

Шинэ асуудлаарх судалгааны тайланг олон нийтэд хүргэх өөр нэг стратегийг туршиж байгаа нь Эрх зүйн хөгжлийн төв ТББ-ын санаачилсан олон нийтийн өрсөлдөөнт мэдээллийн аян юм. Тус байгууллага Эрүүгийн хуульд шинээр туссан заналхийлэх гэмт хэргийн тухай мэргэжлийн тайланд туссан мэдээлэл нь энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдлэг, мэдээлэлгүйгээсээ үйлдэх, өртөх; өртсөн ч цагдаад хандахгүй өнгөрөх хандлага ялангуяа залуучуудын дунд их байгаа тул тэднийг мэдээлэлжүүлэх зорилтын хүрээнд уг тайлангийн агуулгаар нийгмийн сүлжээний цомхон бүтээгдэхүүн боловсруулах уралдаан зарлаад байна.

Уралдаанд ирүүлсэн бүх бүтээлийг хүний эрх, хууль зөрчөөгүй байх талаас нь шүүн тунгаасны дараа олон нийтийн сүлжээнд байршуулж, үзэгч хэрэглэгчдийн саналаар оноо өгч, шалгаруулна. Ингэснээр агуулга бүтээгч болон нийгмийн сүлжээнд идэвхтэй байдаг залуучууд, эрх зүйн чиглэлээр сурч, ажиллаж байгаа оюутан болон залуу мэргэжилтэн, мөн залуучуудаар хязгаарлахгүй нийгмийн сүлжээний бүх хэрэглэгчийг мэдээллээр хангах юм. Мэдлэг, мэдээллийг цэгцтэй түгээх үүднээс төслийн баг уралдааны туршид ТВ, нийгмийн сүлжээгээр энэхүү шинэ төрлийн гэмт хэргийн тухай тайланд түшиглэн олон нийтэд мэдээлэл өгөхөөс гадна цахим шуудан, утас, хуваарьт цагаар ганцаарчилсан зөвлөгөө өгч оролцогчдод дэмжлэг үзүүлж ажиллана.

Иргэний нийгмийн байгууллага, идэвхтнүүд олон асуудлаар тасралтгүй ажиллаж байдаг бөгөөд иргэний нийгмийн орон зайд өдөр тутамдаа өрнөж буй үйл ажиллагааны тухай мэдээлэл нь иргэний боловсролын нэг чухал хэсэг юм. Иргэд, олон нийт дийлэнхдээ

иргэний нийгмийн үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, цахим сүлжээний толин тусгалаар хардаг бөгөөд энэ төрлийн мэдээлэл хязгаарлагдмал, мөн заримдаа өрөөсгөл байх, улмаар иргэний нийгмийн талаар иргэдийн мэдээлэл буруу, дутуу байх эрсдэлтэй байдаг. Тэр тусмаа сайн засаглал, хүний эрх, нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа иргэний нийгмийн үйл ажиллагаа мэдээлэгдэх нь бага байх талтай. Тиймээс бид иргэний нийгмийн өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд идэвхтэй мэдээлэх мэдээллийн үрсгал бий болгох санаачилга гаргасан Тогтвортой хөгжлийн төлөөх сэтгүүл зүй ТББ-тай хамтран ажиллаж эхэллээ. Уг үйл ажиллагааны хүрээнд ННФ нь сэтгүүлч, иргэний нийгмийн байгууллагуудыг холбох, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтмол давтамжтайгаар багцлан мэдээллийн хуудсаар олон нийтэд хүргэхээр ажиллаж байна.

Мөн бид нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалж ажиллаж байгаа орон нутгийн гурван төрийн бус байгууллагыг олон нийтэд танилцуулах баримтат видео нэвтрүүлэг бэлтгэж байна. Баянхонгор аймагт эрх зүйч мэргэжилтэй иргэд, Дорнод аймагт нутгийн иргэд, Ховд аймагт мэргэжлийн сэтгүүлчид төрийн бус байгууллага байгуулан, стратегийн өмгөөлөл хийж, нийтийн өмч, нийтийн эрх ашгийг хамгаалан ажиллаж байгааг харуулсан нэвтрүүлгүүд хийгдлээ. Энэ нь төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, олсон амжилтыг танилцуулаад зогсохгүй нийтийн эрх ашиг хэмээх ойлголтыг тайлбарлан, стратегийн өмгөөлөл хийх алхмууд, тулгарах бэрхшээлийг даван туулах түршлагыг олон нийт, нутгийн иргэдэд танилцуулах таатай боломж бүрдүүлж байна.

# ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО



## ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Манай улсын хувьд 2021 он шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл санааг хуульчлан, эрх зүйн орчныг бэхжүүлсэн чухал шинэтгэлийн жил байлаа. Энэ үйл явцад ННФ-ын зүгээс

(i) шүүхийн тухай хууль тогтоомжийн шинэтгэл, түүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, хяналт тавих; (ii) шүүх эрх мэдлийн хүрээний хөндлөнгийн хараат бус судалгааг дэмжихэд гол анхаарлаа хандуулан ажиллалаа.

## ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ-аас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Шүүхийн тухай хуулийг баталсан нь эрх зүйн хүрээний мэргэжилтнүүд төдийгүй олон нийтийн дунд шүүмжлэл дагуулаад байсан шүүхийн хараат бус байдал зохих түвшинд бэхжинэ, шүүхийн хариуцлага болон шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ гэсэн хүлээлт бий болгосон юм. Шинэчлэн батлагдсан хууль 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн УИХ-ын Тамгын газраас Үндсэн хуульд нэр цохон заасан Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) болон Шүүхийн сахилгын хороо (ШСХ)-ны бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах ажил эхлүүлсэн. ШЕЗ, ШСХ-ны гишүүдийн томилгооны процесс шинээр батлагдсан хуулийн дагуу нээлттэй, ил тод, тэгш шударга явагдах нь цаашид дээр дурдсан хүлээлт биеллээ олоход чухал нөлөөтэй байв.

Бид шүүхийн тухай хууль батлах үйл явцад иргэний нийгмийн байгууллагууд, бие даасан судлаачидтай хамтран ажиллаж, тасралтгүй нөлөөллийн ажил хийсэн бөгөөд дээрх томилгооны процессыг анхааралтай ажиглахын сацуу иргэд олон нийтэд мэдээлэл өгөх, хяналт тавихад бусад төрийн бус байгууллагад боломж олгож ажиллалаа. Тухайлбал, “Бодлогод залуусын хяналт”, “Оюуны-Инноваци” төрийн бус байгууллагууд хамтран санаачлан цахим хэлэлцүүлэг өрнүүлэн залуусын дунд ШЕЗ, ШСХ-ны гишүүнд нэр дэвшихийг уриалан, сонгон шалгаруулалт, томилгооны процесс, нэр дэвшигчдийг танилцуулах үйл ажиллагаа явуулсан нь олон нийтэд мэдээлэл хүргэх гол арга хэрэгсэл байлаа. Цахим нөлөөллийн ажлыг #ҮХНӨ #ХараатБусШүүх #ИлТодТомилгоо зэрэг хаштагаар нийтийн сүлжээнд түгээсэн бөгөөд дээрх хаштагаар дэлгэрүүлэн хайж үзэх боломжтой.



Оюуны-Инновраци ТББ-ын боловсруулсан олон нийтэд зориулсан мэдээллийн хуудас, 2021 он.



Сонгон шалгаруулах ажиллагаа Үндсэн хуулийн цэцэд маргаан үүссэнтэй холбоотойгоор түр тасалдаж, 2021 оны есдүгээр сард дахин сэргэж үргэлжлэв. Улмаар 2021 оны 11 дүгээр сарын 15,16-ны өдөр ШЕЗ, ШСХ-ны гишүүнд нэр дэвшигчдийн томилгооны нээлттэй сонголт болсон нь энэ салбарын томилгоонд түүхэн шинэ үйл явдал болж тэмдэглэгдэн үлдлээ.

2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр УИХ-аас зохион байгуулсан нээлттэй сонсголын үеэр Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчид асуултанд хариулж байгаа нь

Зургийг УИХ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс авав.



Учир нь анх удаа ШЕЗ, ШСХ-ны гишүүнд нэр дэвшигчдийг УИХ-ын Тамгын газраас ийнхүү нээлттэй сонсгол хийж томилсон нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд “салхи хагалсан” алхам болсон юм. ННФ иргэний нийгмийн байгууллагын бусад төлөөллийн хамт энэхүү үйл явцад оролцон, ил тод хариуцлагатай байдлыг хамтран шаардаж, бодлого хэрэгжүүлэх үйл явцад иргэний нийгмийн байгууллага бодит утгаар хяналт тавих үйл хэрэгт үлгэр дуурайлал үзүүлэхийг хичээн ажилласан болно. Томилгооны сонсголыг тогтмолжуулж, үр нөлөөтэй механизм болгон бэхжүүлэхэд иргэний нийгмийн идэвхтэй оролцоо өндөр ач холбогдолтой тул энэ чиглэлээр цаашид хамтын ажиллагаа өрнүүлэх, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь уг сонсголын явцад улам батажсан юм.

Түүнчлэн Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтэд дэмжлэг болох үүднээс уг хуулийн талаарх бодлогын хэлэлцүүлгийн баримтжуулалт, өмнөх хууль тогтоомжийн харьцуулсан шинжилгээг уншигчдад энгийн ойлгомжтой байдлаар хүргэх мэдээллийн сан боловсруулав. Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэнгийн судлаач Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх болон бие

даасан судлаач П.Баярцэцэг нарын боловсруулсан мэдээллийг “Тунгаахуй” дүрслэлийн студи цахим сан болгов. Уг цахим санг [www.shuukh.forum.mn](http://www.shuukh.forum.mn) хаягаар орж танилцана уу.

Энэхүү мэдээллийн санг шүүхийн тухай хуулийн үзэл санааг бэхжүүлэх олон нийт, бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгч бүх талын ойлголтын зөрүүг арилгахад түс болох зорилгоор бүтээсэн бөгөөд цаашид шүүх эрх мэдлийн хүрээнд өрнөх бодлогын шинэтгэлд чухал мэдээллийн эх сурвалж болно гэж найдаж байна.

Шүүхийн шинэтгэлийн бодит үр нөлөөг үнэлэн, бодлогын зөвлөмж хүргүүлж, уг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай Шүүхийн индексийн судалгааг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд олон талын санал шүүмжийг авч эцэслэн боловсруулсан арга зүйн дагуу судалгааны мэдээлэл цуглуулах үе шат амжилттай хэрэгжиж дууслаа. Энэ чиглэлд Оюуны-Инноваци ТББ-тай стратегийн хамтын ажиллагаа эхлүүлсэн бол ММСГ судалгааны компанитай хамтран олон нийтийн санаа бодлыг тандах судалгааг эхлүүлэн нийт 2,000 иргэнийг судалгаанд хамруулаад байна. Шүүхийн индексийн тайланг 2022 онд нийтэд танилцуулах юм.



## ШҮҮХИЙН САЛБАРЫН СУДАЛГААГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шүүхийн тухай хууль эрх зүйн орчин шинэчлэгдсэнээр судалгаа шинжилгээний фокус түүнийг даган өөрчлөгдөж байна. Тухайлбал, шүүхийн ил тод байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, иргэдийн шүүхэд хандах эрхийн баталгаажилтад чухал шаардлагатай бодлогын судалгаа, мониторинг хийх хэрэгцээ шаардлагыг дурдаж болно.

ННФ-ын 2021 оны судалгааны нээлттэй сонгон шалгаруулалтаар манай улсын шүүхийн тогтолцооны оновчтой зохион байгуулалтыг тодорхойлох бодлогын судалгаа, шүүхийн шийдвэрийн ил тод байдалд мониторинг хийх байгууллагыг сонгон шалгарууллаа. Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэнгийн судлаачид шүүхийг тойргоор болон дагнасан байдлаар зохион байгуулахад анхаарах асуудлыг судалж бодлогын зөвлөмж боловсруулсан нь Шүүх байгуулах тухай хуулийн төсөл боловсруулахад шүүд ач холбогдолтой эх сурвалжийн нэг болсон гэдэгт найдаж байна. Түүнчлэн өмнөх жилүүдэд хийгдсэн шүүхийн шийдвэрийн судалгааг дэмжин ажиллах явцад түгээмэл тулгарч байсан нэг бэрхшээл нь шүүхийн шийдвэрийн цахим санд шийдвэр цаг тухайдаа, бүрэн орохгүй, хайж олоход бэрхшээлтэй байсан явдал юм. Үүнийг үл суурьтай судлах үүднээс Хөгжлийн эрх зүйн төв ТББ-ын судлаачидтай хамтран хоёр үе шаттай үйл ажиллагаа явууллаа. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийн цахим санд мониторинг хийх;
2. Шүүхийн шатанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг үнэлж бодлогын зөвлөмж боловсруулах.

Эхний үе шат амжилттай хэрэгжин мониторингийн үр дүн хэвлэн нийтлэгдэж олон нийтийн хүртээл боллоо. Тус мониторингийн тайланг ШЕЗ-д танилцуулан, шүүхийн шийдвэрийн нээлттэй санг хэрэглэгчдэд

ээлтэй, боловсронгуй болгох чиглэлд хамтран ажиллахаар төлөвлөж байна. Цаашид шүүхийн болон шүүхийн өмнөх шатанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг стандартын дагуу нийтэд нээлттэй болгох замаар хариуцлагын тогтолцоог өөрийг нь хариуцлагатай, нээлттэй болгоход анхаарч ажиллах болно. Мөн уг мониторингийн мөрөөр шүүхийн шатанд хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг судалж, бусад улсын сайн туршлагыг харьцуулан санал зөвлөмж боловсруулах ажил хэрэгжилтийн шатандаа явж байна. Энэхүү хоёр судалгаа нь шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг үнэлэх цогц судалгаа болох бөгөөд цаашид Шүүхийн индексийн судалгаанд хамтатган давтамжтай үнэлэн ил тод байдлын ахиц дэвшлийг хэмжих боломж бүрдэнэ.

Шүүх эрх мэдлийн хүрээний эрх зүйн орчинд хуульч, өмгөөлөгчдийн эрх зүйн байдал хамаарахын хувьд Өмгөөллийн тухай хууль шинээр батлагдсантай холбоотойгоор шүүгч, прокурор бусад хуульчийг эгнээндээ багтаасан хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдлыг эргэн харж хуулийг нь шинэчлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна. Бодлогын шийдэл тодорхойлох энэ цаг мөчид бид хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын удирдлага, бүтэц, чиг үүргийн талаарх харьцуулсан судалгааг мөн дэмжиж ажиллалаа. Фиделитас партнерс ХХН-ийн хуульч судлаачдын баг АНУ, Австрали, Япон болон ОХУ, Беларусь, Литва зэрэг пост-социалист орны хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагыг судалж, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд өгөх тодорхой санал шүүмжийг түүнд багтаан боловсруулж гаргалаа. ННФ-ын зүгээс бодлого боловсруулагчдад энэхүү тайланг хүргэж мэдээллээр хангаж ажиллав.

Шүүхийн үр дүнтэй зохион байгуулалт, тогтолцоо бүрдүүлэх нь шинэ хуулийн хэрэгжилтэд чухал үүрэгтэй. Юуны өмнө шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулахаас гадна Монгол Улсын засаг захиргааны харьяаллаар хүн амын нягтрал, хэрэг маргааны тоо, материаллаг болон хүний нөөцийг зохистой хуваарилах зэрэг хүчин зүйлсийг харгалзан шүүхийн тогтолцоог авч үзэх шаардлагатай. Судлаачдын зүгээс тойргийн болон дагнасан шүүх байгуулах талаар тооцоо судалгаанд үндэслэн бодлогын хувилбар санал болгосныг энэхүү судалгаанаас харах боломжтой ([www.fogim.mn](http://www.fogim.mn) сайтаас бүрэн эхээр нь үзнэ үү).



2018 оноос эхэлсэн шүүхийн шийдвэрийн судалгааны тэтгэлэгт төслүүдийн ач холбогдлыг нэмэгдүүлэх үүднээс бид 2021 онд шүүхэд хэрэглэх хуулиуд тэр дундаа хувийн эрх зүйн хууль тогтоомжууд, эрүүгийн хуульд шинээр оруулсан гэмт хэргийн шийдвэрлэлт зэрэг асуудалд түлхүү анхаарч дэмжлэг олголоо. Энэ хүрээнд хоёр удаагийн сонгон шалгаруулалтаар нийт 35 төсөл хүлээн авснаас Шүүхийн шийдвэрийн судалгааны редакцын зөвлөлтэй хамтран 11 төсөл шалгаруулж тэтгэлэг олголоо. Редакцын зөвлөлийн гишүүд 2020-2021 онд хийгдсэн нийт 19 судалгааны тайланг хянан тохиолдуулж, үүнээс 13 тайланг дөрвөн цувралаар нийтийн хүртээл болгоод байна.

## Шүүхийн шийдвэрийн судалгааны цувралд нийтлэгдсэн судалгааны жагсаалт

Цуврал 1 Редактор Д.Золжаргал		
1	Б.Ананд, М.Балжинсүрэн, Л.Анхбаяр	Зээлийн гэрээ цуцалснаас хойш хүү шаардсан маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн шинжилгээ
2	Г.Давааням	Гэрээний эрх чөлөөний зарчмаас үүдсэн ажилтны үл өрсөлдөх үүрэг: Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд хийсэн дүн шинжилгээ
3	Д.Ганхүрэл, А.Түвшинтөгс, Х.Номундарь	Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг бүртгүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг хэрэглэж буй шүүхийн практикийн шинжилгээ
Цуврал 2 Редактор Г.Оюунболд		
4	Ц.Цэлмэг, Д.Оросоо	Залилан мэхлэх гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийн харьцуулсан шинжилгээ
5	О.Мөнхцэцэг	Улсын Дээд шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ
6	Б.Батзориг	Авлигын хэрэг шийдвэрлэсэн Улсын Дээд шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ
7	Б.Пүрэвсүрэн	Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийн дүн шинжилгээ
Цуврал 3 Редактор Н.Отгончимэг		
8	Б.Анхзаяа, Ц.Уянга	Цалин хөлсний маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн шинжилгээ
9	Б.Баялагмаа, Б.Наранцэцэг, Э.Энхцэцэг, Б.Уянга	Иргэний хэрэг үүсгэх ажиллагаа дахь шүүхэд мэдүүлэх эрхийн хэрэгжилт: Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн жишээн дээр
Цуврал 4 Редактор С.Билгүүн		
10	А.Түвшинтөгс, Н.Лхамцэрэн, Д.Ганхүрэл, Э.Золзаяа	Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлтэй хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик, харьцуулсан дүн шинжилгээ
11	Б.Ариунзаяа, Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн,	Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцооны талаарх онолын асуудал ба Монгол Улсын шүүхээр эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй байдал
12	Л.Банзрагч	Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах
13	М.Ванчигмаа	Эдийн бус гэм хорыг хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

## ХҮНИЙ ЭРХ

ННФ-ын хөтөлбөрүүдийн хүрээнд Монгол Улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах, иргэдийн хүний эрхийн боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж тодорхой үйл ажиллагааг олон жилийн туршид явуулж ирсэн билээ. Сүүлийн хоёр жилд “Ковид-19” цар тахлын дэгдэлтийн улмаас хүн

төрөлхтөн хүнд сорилттой нүүр тулгарч буйгаас хүний эрхийн хэрэгжилтэд ч бэрхшээл учраад байна. Энэ цаг үед Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум (Хүний эрхийн форум) хүний эрхийн салбарт гарч болзошгүй үхралтаас сэргийлэх, өмнөх ололтоо бататгахыг эрмэлзэн ажиллалаа.

### ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэхэд эрх зүйн орчин нэн чухал билээ. Манай улсад 2021 онд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль анх удаа батлагдсан нь онцлох үйл явдал байсан төдийгүй уг хуулийг баталсан Азийн анхдагч орон боллоо. Хуулийн төсөл боловсруулах эхний санаачилгыг 2016 онд Хүний эрхийн форум, Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) хамтран гаргаж, тухайн үеийн ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж манлайлан ажилласан билээ.

Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоонд шинээр бий болж буй эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмд зориулж “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” гарын авлагыг боловсруулаад байна. Мөн тус тогтолцоог

“Хүний эрхийн тухай ярилцъя” хэлэлцүүлгийн хоёр ч дугаараар олон нийтэд танилцууллаа.

Цар тахлын үед хомс төсвөөр ажиллаж буй ХЭҮК-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тэтгэлэг олгов. Энэ оноос эхлэн жил бүр зохион байгуулахаар төлөвлөж буй “Хүний эрхийн форум – 2021” үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Мөн 2020 онд шинэчлэн найруулсан Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 30 дугаар зүйлийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн “Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага үр нөлөөтэй оролцох нь” сэдэвт судалгааг хийж гүйцэтгэлээ. Тус судалгаа нь ХЭҮК-ын зэрэгцээ дэргэдээ иргэний нийгмийн зөвлөлтэй хараат бус бусад байгууллагад тодорхой хэмжээнд ашиглагдана гэдэгт бид итгэлтэй байна.

Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум буюу Хүний эрхийн форум нь 2010 оноос эхлэн эдүгээ 11 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хүний эрхийн чиглэлээр ажилладаг 50 гаруй төрийн бус байгууллагыг нэгтгэсэн сайн дурын сүлжээ юм. Тус Форум нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” механизмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч бөгөөд сайн туршлага нь олон улсын түвшинд түгээгдсэн билээ.



Энэхүү судалгаагаар судлаач Л.Галбаатар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Иргэний нийгмийн зөвлөлийг зохицуулсан заалтад дүн шинжилгээ хийж, зөвлөл байгуулах болсон учир шалтгаан, өмнөх хуулийн хүрээнд орон тооны бус зөвлөл хэрхэн ажиллаж ирсэн зэргийг судлан шинжилснээс гадна бусад улсын ижил төстэй бүтцийг харьцуулах замаар зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагааны хэлбэр, ХЭҮК-той үр дүнтэй хамтран ажиллах нөөц боломжийн талаар тодорхой санал, зөвлөмж боловсруулав.



ННФ нь Хүний эрхийн форумын гишүүн байгууллагын хувьд тус Форумтай 2021 онд ч идэвхтэй хамтран ажиллалаа. Өнгөрсөн онд Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцсэн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” механизмын III циклээс Монгол Улсын Засгийн газар нийт 190 зөвлөмж хүлээн авснаас 170 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан билээ. Анхны циклээс авсан зөвлөмжийг төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд тус тусдаа орчуулснаас үүдэн хүлээгдэж буй үр дүн дээр ойлголтын зөрүү үүссэнийг залруулах зорилгоор орчуулгыг анхнаас нь нэгтгэх зөвшилцөлд 2013 онд хүрсэн билээ. Энэ дагуу дээрх зөвлөмжийн орчуулгын эхний төслийг төрийн

байгууллага хийн, тус орчуулга дээр Хүний эрхийн форум ажиллаж саналаа өглөө. Мөн тус зөвлөмж дээр ажиллах Хүний эрхийн форумын ажлын хэсгүүдийг байгуулсан бөгөөд иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм соёлын эрх, бүлгийн эрх, хүний эрхийн үндэсний механизм зэрэг сэдвийн хүрээнд ажиллаж эхлэв. Эхний ээлжид тус зөвлөмжүүдээс хүлээгдэж буй үр дүнг гаргаж ХЗДХЯ-нд хүргүүлээ. Хүний эрхийн форум 12 дугаар сарын 8-ны өдөр Монголын Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран “Монгол дахь хүний эрхийн төлөв байдал” цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, тус хэлэлцүүлгийн үеэр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжүүдээс хүлээгдэж буй үр дүнг олон нийтэд танилцууллаа.

## ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, МЭДЛЭГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ НЬ

ННФ-аас хүний эрхийн боловсрол, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, мөн нийгэмд өрнөж буй хүний эрхийн “халуун” сэдвээр ярилцдаг уламжлалт хэлэлцүүлгийг 2021 онд цахим болон танхимаар хослуулан явууллаа. Цаг үеийн нөхцөл байдалд үндэслэн “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх нь”, “Цар тахал-Хүний эрх-Тэгш байдлын зарчим”, “Ковид-19-Сонгууль-Сонгогчийн эрх”, “Хүний эрх соёл болох нь”, “Сэтгэцийн эрүүл мэнд ба Хүний эрх”, “Ахмад настны эрх”, “Гэр бүлийн хүчирхийллээс ангижиръя”,



Чухал сэдэв #16:  
Сэтгэцийн эрүүл мэнд ба Хүний эрх



*“Гэр бүлийн хүчирхийллээс ангижиръя” хэлэлцүүлэг, 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр.*

“Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо” зэрэг сэдвээр ярилцлаа. Эдгээр хэлэлцүүлэг нийт 60,928 хүнд хүрч 2,261 хүн хариу үзүүлэн, 21,032 хүн үзжээ.

Дээрх ярилцлагыг цахим болон танхимаар хослуулан явуулж байгаатай холбогдуулан зарим хэлэлцүүлэгт мэргэжилтнүүдийг түлхүү оролцуулахыг бид зорьсон билээ. Энэ хүрээнд “Сэтгэцийн эрүүл мэнд ба Хүний эрх” хэлэлцүүлэгт салбарын 20 мэргэжилтнийг урьж оролцуулан сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр манай улсад тулгамдаж буй асуудлаар санал солилцсон ба уг

асуудлыг ХЭҮК стратеги төлөвлөгөө боловсруулахдаа анхаарч авч үзэхээр болсон юм. Хэлэлцүүлгээс гарсан гол саналуудыг хураангуйлан “Чухал сэдэв” цувралд нийтлүүлээ.

Хүний эрхийн боловсрол мэдлэг түгээн дэлгэрүүлэх хүрээнд хөтөлбөрөөс зохион байгуулсан дийлэнх үйл ажиллагааг цахимаар үзэх боломжтой болсон бөгөөд нийт 14 төрлийн цахим хэлэлцүүлэг 64,416 хүнд хүрч 2,455 хүн хариу үйлдэл үзүүлэн, нийт 27,778 хүн үзсэн тоон үзүүлэлт байна.

## ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ӨДРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүний эрхийн форум нь 2014 оноос эхлэн жил бүрийн 12 дугаар сарын 10-нд Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд тайван жагсаал зохион байгуулж ирсэн. Цар тахлын улмаас олноороо цугларан энэ өдрийг тэмдэглэх боломж хязгаарлагдсан ч 2021 онд уг арга хэмжээг цахим болон танхимаар хослуулан зохион байгууллаа.

НҮБ нь “Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн сахих нь бүх нийтийн аюулгүй байдал, энх тайвны үндэс” болохыг тунхаглаж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэмээх түүхэн чухал баримт бичгийг 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталснаас хойш жил бүрийн энэ өдрийг “Хүний эрхийн өдөр” хэмээн дэлхий нийтээрээ тэмдэглэдэг уламжлал тогтсон билээ.

Энэ онд хүний эрхийн өдрийг тохиолдуулан “Эрхээ шаардъя” уриан дор нэг сарын цахим аян өрнүүллээ. Тус аяны хүрээнд “Бид оролцох эрхтэй”, “Бид зорчих эрхтэй” сэдвээр тухайн эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг орон даяар сонсох зорилгоор цахим хэлэлцүүлэг өрнүүллээ. Нэг сарын түршид өрнөсөн цахим аян нийт 90,000 гаруй хүнд хүрснээр тэд Хүний эрхийн форумын цахим эвентийг үзэж сонирхон, мөн санал бодлоо хуваалцсан байна. Уг аяны хүрээнд нийт 40 пост, видео, мэдээ, мэдээлэл түгээснээс гадна аян эхлэхэд мөн аяны төгсгөлд хэвлэлийн хурал зохион байгуулж, мэдээллийн хэрэгслүүдээр дамжууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор “Хүний эрхийн форум – 2021” олон улсын хүний эрхийн өдөр зохион байгуулагдсан бөгөөд тус форумыг зохион байгуулах Ажлын хэсэгт Хүний эрхийн форумыг

төлөөлөн Монголын эмнести интернэйшнл, Нээлттэй Нийгэм Форум байгууллагууд багтаж ажиллалаа. Мөн Форумын үндсэн хуралдааны үеэр Хүний эрхийн форумын сүлжээний нийт гишүүн байгууллагатай зөвлөлдөн боловсруулсан илтгэлийг ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан тавилаа. Үүний зэрэгцээ иргэний, улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм соёлын эрх, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, уур амьсгалын өөрчлөлт ба хүний эрх сэдэвт салбар хуралдаан тус бүрд Хүний эрхийн форумын гишүүд илтгэл танилцуулж оролцлоо. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан уг Форум цаашид жил бүр болох бөгөөд түүнээс гарсан зөвлөмжийг дараа жилийн Форумаар хэлэлцэх болсноороо ач холбогдолтой юм.



“Хүний эрхийн форум – 2021” дээр Хүний эрхийн форумыг төлөөлсөн үндсэн илтгэлийг ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер танилцууллаа, 2021.12.10, Төрийн ордон.

## ЦАР ТАХЛЫН УЛМААС ҮҮСЭЭД БУЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ХАРИУ ҮЙЛДЭЛ

Цар тахлын амаргүй үед ННФ хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлээр бусад төрийн бус байгууллагатай хамтран хуулийн хэрэгжилтэд судалгаа, мониторинг хийх, мөн зарим төрийн байгууллагын үйл ажиллагаанд техникийн болон арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа. “Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг

боловсруулах үе шатад хийсэн дүн шинжилгээ” судалгаа нь дээр дурдсан үйл ажиллагааны нэг юм. Мөн өнгөрсөн оны сүүлээр эхлүүлсэн “Хөл хорио ба эх орондоо ирэх эрх”, “Цагдаагийн байгууллага, алба хаагч “Бүх нийтийн бэлэн байдал”-ын үед мөрдөж ажиллах хууль, дүрэм, журмын хэрэгжиж буй байдал” судалгааны ажлыг дуусган үр дүнгийн тайланг олон нийтэд хүргэлээ.

“Ковид-19” цар тахлын үед хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд туслалцаа үзүүлэх зорилгоор мониторинг, бодлогын судалгаа, стратегийн өмгөөлөл хийхэд дэмжлэг үзүүлж ажиллалаа. Энэ хүрээнд өнгөрсөн онд хөл хорио ба эх орондоо ирэх эрх, цар тахлын хууль, цар тахлын үе дэх хууль сахиулах ажиллагаанд баримтлах хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, засаж сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулав.





Түүнчлэн иргэний болон улс төрийн зарим эрхийн хэрэгжилтэд мониторинг хийх тэтгэлгийг Глоб интернэйшнл төв ТББ-д олгоод байна. Хүний эрхийн форум Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох талуудад хүргүүлээ.

Дэлхий нийтээр цар тахлаас үүдэлтэй гэр бүлийн хүчирхийлэл өссөн статистик мэдээлэл байгаа бөгөөд манай улсын хувьд ч мөн адил байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн тухайд 7-30 хоногийн баривчлах шийтгэлийг нийслэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төв,

Баривчлах байр, орон нутагт Цагдаагийн газрын харьяа баривчлах байруудад хэрэгжүүлж байгаа бөгөөд баривчлах шийтгэл авсан нийт хүний 70 гаруй хувийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил эзэлдэг ажээ. Энэ шийтгэлийг эдлэх хугацаанд Зан үйлд нөлөөлөх тодорхой цагийн сургалтад суухыг даалгадаг бөгөөд хууль хэрэгжээд багагүй хугацаа өнгөрч байгаа ч үр дүнтэй сургалтын хөтөлбөргүй явж ирсэн нь энэхүү зохицуулалтын үр нөлөөг бууруулж байна. Иймээс ННФ өнгөрсөн онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байр, Баривчлах төвд сургалтын хөтөлбөр боловсруулахад нь зориулж тэтгэлэг олгосон бөгөөд энэ онд хөтөлбөрүүд боловсруулагдлаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байр, Баривчлах төв нь Зан үйлд нөлөөлөх найман төрлийн сургалтын хөтөлбөр боловсруулаад байна. Тус хөтөлбөрт Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ-аар хөндлөнгийн шүүмж хийлгэн, улмаар мэргэжлийн сэтгэл зүйч хөтөлбөр боловсруулах багт арга зүйн зөвлөгөө өгч ажилласны дүнд нийт сургалтын хөтөлбөр бэлэн боллоо. Тус хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалтад 21 аймгийн төлөөлөл оролцох юм.





## ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ

Хөтөлбөрийн хүрээнд бид Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бие даасан судалгаа, мониторингийн үр дүнгээр хангахын зэрэгцээ, шинэ эрх зүйн орчинд ажиллах эрх зүйн соёлыг төлөвшүүлэх, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах шатанд иргэний нийгмийн санал бодлыг нэгтгэн

хүргэхэд гол анхаарлаа хандуулж ажиллалаа. Энэ онд цар тахлын улмаас тулгарч буй сорилтыг даван туулахад шаардлагатай эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд хувь нэмэр оруулахын зэрэгцээ эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг үнэлэх судалгаа шинжилгээнүүд хийгдлээ.

### ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ҮЙЛ ЯВЦАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАД ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ НЬ

ННФ эрх зүйн шинэ орчныг иргэний нийгэмд таниулах, энэхүү шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд иргэний нийгмийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд бүх талаар анхаарч ажилладаг билээ. Энэ хүрээнд “Хуулийн хэлэлцүүлэг”, ажиглалт мониторинг, гарын авлага, судалгаа шинжилгээ, экспертийн хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Өнгөрсөн онд цаг үеийн нөхцөл байдалд хариу үзүүлэх хүрээнд Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн

хэрэгжилтэд үнэлгээ хийх хэлэлцүүлгийг цахимаар явуулж, хэлэлцүүлгийн саналд тулгуурлан бэлтгэсэн хуулийн шүүмжийг холбогдох талуудад хүргүүлээ. Мөн эрүүгийн хууль тогтоомжид шинээр орж ирсэн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, цагдан хорих хэлэлцүүлэгт мониторинг хийх гарын авлага боловсруулах ажлыг эхлүүлээ. Тус гарын авлага нь энэ үйл явцад ажиглалт хийхийг хүссэн хэн бүхэн ашиглаж болохуйц байх бөгөөд гарын авлага ашиглах туршилтын мониторингийг ирэх онд хийхээр төлөвлөөд байна.



Эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд чиглэсэн дөрвөн тусдаа бодлогын судалгааг дэмжиж 2020 онд эхлүүлсэн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй байдалд дүн шинжилгээ хийх нь”, “Шинэ эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт сумын түвшинд”, “Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал”, “Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт” судалгааны тайлангууд нийтэд хүрлээ. Түүнчлэн 2021 онд “Мөрдөх албаны талаарх харьцуулсан судалгаа”, “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахад тулгамдаж буй асуудал”, “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал”, “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Тулгамдаж буй асуудал” зэрэг сэдвээр эхлүүлсэн судалгааны ажил дуусаж үр дүн нь нийтийн хүртээл боллоо. Мөн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн давхардал”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь зөвшөөрөл, тулгамдсан асуудал”, “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, түүний хэрэгжилтийн байдал” судалгааны ажлууд дуусах шатандаа орж байгаа бөгөөд тайлан нь ирэх онд хэвлэгдэх юм.

Манай улсад өрнөж буй оролцооны чиглэлээрх хууль тогтоомжийн шинэчлэлд 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль онцгой байр суурь эзэлнэ. Тус хуулиар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсний үндсэн дээр хуулийн үзэл баримтлал, танилцуулга, төслийг боловсруулах, улмаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, холбогдон гарах зардлын тооцоог хийх, төсөл боловсруулах явцдаа иргэн, төр, төрийн бус байгууллагаас санал авах үйл явцыг нарийвчлан зохицуулсан байдаг. Гагцхүү энэхүү журам, шаардлага хууль тогтоох явцад хэрхэн мөрдөгдөж байгаа нь чухал юм. Тиймээс ННФ “Хууль

тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн жишээн дээр авч үзэх нь” сэдэвт судалгааны ажил эхлүүлж үр дүнг олон нийтэд хүргэхэд бэлэн болоод байна.

Түүнчлэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хуульч бэлтгэн гаргаж буй өнөөгийн нөхцөл байдлыг эргэн харах хэрэгцээ шаардлага өндөр байгааг үндэслэн АНУ, БНСУ, ХБНГУ-ын хуульч бэлтгэх тогтолцоог судлан “Хуульч бэлтгэх гадаад орнуудын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны тайланг нийтлэн гаргалаа.



*Зарим тохиолдолд судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэхийн зэрэгцээ хэвлэхийн өмнө экспертийн хэлэлцүүлэг хийж, шүүмжийг тайланд тусгах нь маргаан бүхий асуудлаар олон талын дуу хоолойг сонсох боломж бүрдүүлэх тул “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал” тайлангийн урьдчилсан дүнг УИХ-ын гишүүн, төрийн бус байгууллага, их дээд сургуулийн багш нарыг оролцуулан танилцуулж, гаргасан шүүмж, саналыг тайланд тусгалаа.*



*Хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэлийн асуудлыг хөндөж буй энэ цаг үед Доктор Ш.Чулуунбат, Д.Сүнжид, судлаач А.Сэргэлэнтуяа нар БНСУ, ХБНГУ, АНУ-ын хуульч болох үе шат, хуулийн сургуульд элсэн суралцахад тавигдах шаардлага, хичээлийн хөтөлбөр, кредит цаг, сургуулийн магадлан итгэмжлэл, хуульчийн шалгалтын агуулга, бүтэц зэрэг нийтлэг асуудлыг уг судалгаагаар авч үзлээ.*

Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдан мөрдөгдөөд багагүй хугацаа өнгөрч байгаа ч энэ асуудлаар нийгэмд багагүй маргаан мэтгэлцээн өрнөөд байгаа билээ. Үүнтэй холбогдуулан хууль тогтоох байгууллага тухайн хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал яригдаж байгаа бөгөөд бид

эдгээр хуульд хийсэн суурь судалгааг ирэх онд хэвлэн нийтэлж, олон нийтийн хүртээл болгохоор ажиллаж байна. Үүний зэрэгцээ хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт боловсруулах Ажлын хэсгийн зарим гишүүнийг гадаад улсын түршлага судлахад зориулж тэтгэлэг олгосон бөгөөд цар тахлын улмаас энэ ажил хойшилсон болно.

## ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ, БЭХЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

2012 оноос эхэлсэн эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хохирогчийн эрх зүйн хамгаалалт сайжирч, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн барагдуулалт сайжирна хэмээх олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын хүлээлт байсан. Тиймээс бид хохирол барагдуулах үйл ажиллагаатай холбоотой цуврал судалгааны ажил гүйцэтгэж байгаа бөгөөд өнгөрсөн онд эхлүүлсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлгийн хэрэгжилт” буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах зохицуулалтын хэрэгжилтэд үнэлгээ өгсөн тайланг хэвлүүллээ. Мөн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт: Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ” судалгааны тайланг хэвлэж олон нийтийн хүртээл болгосноор энэ чиглэлээр дөрвөн цуврал судалгаа олон нийт, шийдвэр гаргагчдын гарт хүрлээ. Цаашид ч тодорхой судалгааны ажлууд үргэлжлэн хийгдэж байна.

“Хохирол нөхөн төлүүлэх үндэсний тогтолцоо: Шударга ёсыг сэргээн тогтоох нь” сэдвийн хүрээнд хоёр цуврал цахим хэлэлцүүлэг зохион байгуулж энэ хүрээнд хийсэн судалгааны дүнг олон нийтэд танилцууллаа. Мөн өнгөрсөн онд эхлүүлсэн “Хохирлын тогтолцоо” кампанит ажил амжилттай өрнөж, талуудын анхаарлыг энэ асуудалд хандуулж чадсан юм. Тус кампанит ажлын үеэр бэлгийн халдашгүй байдал, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны эсрэг болон хүн алах, авлигын гэмт хэргийн асуудлаар долоон видео, таван постер, 10 нийтлэл бэлтгэж түгээлээ. Тус контентууд давтагдсан тоогоор

нийт 2,027,400 хүнд хүрч, үүнээс 934,500 хүн хариу үйлдэл үзүүлсэн дүн гарлаа. Тус аяны төгсгөлд хийсэн “Хохирлоо хэрхэн барагдуулах вэ?” цахим форум нийт 284 гаруй мянган хүнд хүрч, 26 мянга гаруй хүн хариу үйлдэл үзүүлжээ.

Хохирол барагдуулах тогтолцоог бүрдүүлэх, сайжруулах асуудлаар шүүх, хүний эрхийн үндэсний байгууллага, холбогдох яам анхаарч, тодорхой ажил санаачилж эхэлсэн нь энэ чиглэлээр ахиц дэвшил гарч буйг илтгэн харуулж байна.



“Хохиролгүй барагдуулъя” кампанит ажлын үеэр бэлгийн халдашгүй байдал, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны эсрэг болон авлигын гэмт хэргийн хохирол барагдуулалттай холбогдуулан гаргасан бүтээгдэхүүний постерууд

## ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

Эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд бодлогын судалгаа шинжилгээ хийхийн зэрэгцээ үр дүнг тухай бүрд олон нийт, шийдвэр гаргагчдад таниулах нь тун чухал юм. Үүний нэг арга хэрэгсэл нь хөтөлбөрөөс зохион байгуулж буй цахим хэлэлцүүлэг билээ. 2021 онд “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ”, “Өршөөлийн хуулиудад хийсэн дүн шинжилгээ”, “Өршөөлийн хуулиудад хийсэн дүн шинжилгээ-Татварын өршөөл”, “Гэрч, хохирогчийн хамгаалалт” сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүллээ. Эдгээр хэлэлцүүлэг нийт 73,518 хүнд хүрч, 2,406 хүн хариу үйлдэл үзүүлэн, видеог нийт

34,254 хүн үзэж сонирхжээ. Мөн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийсэн судалгааны ажлыг танилцуулах уулзалтыг УДШ-ийн Эрүүгийн танхим, ХЗДХЯ, ЦЕГ-ын холбогдох албан тушаалтныг оролцуулан тус тус зохион байгууллаа.

ННФ нь эрх зүйн шинэчлэлийн явцад хийсэн судалгааны тайланд олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах зорилгоор гол үр дүнг хураангуйлан өнгөрсөн оноос “Судалгааны тойм” байдлаар хүргэж эхэлсэн.

Өнөөгийн байдлаар нийт 22 дугаар олон нийтийн хүртээл болжээ.

## СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

Хохирол барагдуулах тогтолцоог бэхжүүлэх хүрээнд жишиг тогтоох зорилгоор дараах сэдвээр стратегийн өмгөөллийн тэтгэлэг олголоо. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх стратегийн өмгөөлөл;

- “Цагаан эрэг”-ийн хохирлыг арилгах нийтийн эрхийн өмгөөлөл;
- Ковид-19 цар тахлын үед захиргааны хууль бус шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг барагдуулах;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах жишиг тогтоох.

## МОНИТОРИНГ

Цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй хөл хорионы дэглэмд хууль сахиулах ажиллагаатай холбоотой гомдол цөөнгүй гарч байгаатай холбогдуулан цагдаагийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийх тэтгэлгийг Монголын эмнести интернэйшнл ТББ-д олгов. Тэтгэлгийн хүрээнд хийсэн баримтжуулалтад тулгуурлан дараах сэдвээр цахим хэлэлцүүлгийг цувралаар зохион байгууллаа. Үүнд:

- Ковид 19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа: “Жагсаал, цуглаан”
- Ковид 19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа: “Чөлөөтэй зорчих эрх”

- Ковид 19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа: “Хүч, тусгай хэрэгсэл”

Мөн хөл хорионы улмаас гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо өсөж байгаатай холбогдуулан гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ)-д олгосон тэтгэлгийн үйл ажиллагаа энэ онд үргэлжиллээ. Мониторингийн зарим дүнг танилцуулах уулзалтыг үг байгууллага 12 дугаар сард зохион байгуулав.

Мөн авлигын шинжтэй гомдол мэдээллийн шийдвэрлэлтэд хийсэн мониторингийн дүнг Монитор цувралын 28 дугаарт нийтлэн гаргалаа.



# НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

## ТӨСВИЙН ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Монгол Улс байгалийн арвин баялаг нөөцтэй ч иргэдийн орлогын ялгаа жилээс жилд гүнзгийрч, хүн амын 30 орчим хувь нь үндэсний ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа<sup>1</sup> нь тухайн нийтийн баялгийн удирдлага хүн амын олонход үр ашгаа өгөхүйц түвшинд явагдахгүй байгааг харуулна. Иргэдийн амьдралын тэгш бус байдалд дорвитой ахиц гарахгүй байгаа нь Жини коэффициент улсын дунджаар 0.31<sup>2</sup> байгаагаас мөн харагддаг. Түүнчлэн төрийн аудитын байгууллагын хяналт шалгалтаар улсын төсвийн зарцуулалттай холбоотой зөрчлүүд ч жил бүр давтагдан илэрсээр байна. Иймд нийтийн баялгийг иргэн бүрийн амьдралын чанарыг дээшлүүлэхүйц хэмжээнд удирдахад юуны өмнө Монгол Улсын төсвийн удирдлага, түүний ил тод, хариуцлагатай байдлыг өнөөгийн түвшнээс дээшлүүлэх шаардлагатай. Үүнээс гадна төсвийн зарцуулалтын хяналт, мониторинг туйлын чухал.

Иргэний нийгмийн олон жилийн шаргуу зүтгэлийн дүнд төсвийн мэдээлэл харьцангуй нээлттэй болсноор

иргэд, олон нийтийн зүгээс төсөвт хяналт, мониторинг хийх идэвх өндөр болжээ. Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2015 оноос ННФ иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран орон даяар жил бүр хяналт, мониторинг хийж, үр дүнг төр засаг, олон нийтийн анхааралд оруулж ажилласан нь үг хууль хэрэгжихэд чухал түлхэц болсон гэж бид үздэг. Уг хуулийн дагуу төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг 2019 онд улсын төсвийн ерөнхийлөн захирагчид, тэдгээрт хамаарах байгууллагууд 91.5 хувь; аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид, тэдгээрт хамаарах байгууллагууд 87.9 хувь хэрэгжүүлсэн талаар Үндэсний аудитын газраас 2020 онд гаргасан “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан”-д дүгнэжээ.

Төсвийн мэдээлэл илүү нээлттэй болсон нь улсын төсвийн хөрөнгийн үр ашиггүй, зүй бус ашиглалтыг зөвхөн ил болгоод орхихгүй, төрөөс шударга ёс

<sup>1</sup> Эх сурвалж: <https://www.worldbank.org/mn/news/press-release/2021/12/30/mongolia-s-2020-poverty-rate-estimated-at-27-8-percent>

<sup>2</sup> “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-гаар сард нэг хүнд ногдох зардалд үндэслэн Жини коэффициентийг тодорхойлдог (Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, [www.1212.mn](http://www.1212.mn)).

шаардах боломж олгосноор илүү олон иргэн нийтийн баялгийн буруу ашиглалт, авлига, танил талдаа давуу байдал олгож байгааг ил болгоход анхаарал хандуулж, төсвийн мэдээлэл, нээлттэй өгөгдлийг ашиглан нийгмийн сүлжээгээр мэдээлэл түгээн хариуцлага нэхдэг болжээ. ННФ-аас орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын төсвийн мониторингийн төслийг дэмжин ажилласны дүнд тэд төсвийн зарцуулалтад энгийн дүн шинжилгээ хийх, иргэд болон нутгийн

захиргааны байгууллагад үр дүнгээ танилцуулах, нийтийн сонсгол шаардах, ИТХ-тай хамтран сонсгол зохион байгуулах, төсөв захирагчидтай хамтран ажиллахад түршлагажиж байна.

Бид 2021 онд нийтийн хөрөнгийн удирдлага, зарцуулалтыг оновчтой болгоход хувь нэмэр оруулах зорилго дэвшүүлэн дараах үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэлээ.

## УЛСЫН ТӨСӨВ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Өнгөрч буй онд бид (i) Монгол Улсын төсөв, санхүүгийн зарцуулалт, удирдлагатай холбогдох дүн шинжилгээ; (ii) улсын төсвийн төлөвлөлт, хяналт болон төсвийн ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, баримт

бичгүүд боловсруулахад санал зөвлөмж оруулах; (iii) төсвийн асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэл хүргэхэд голлон анхаарч ажиллалаа.

### Судалгаа шинжилгээ

Төсөв, санхүүгийн удирдлага, зарцуулалтын хүрээнд Ковид-19 цар тахлын үед Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор уул уурхайн салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудаас улсын төсвөөр дамжуулалгүй гаргаж буй зардлыг авч үзсэн “Төсвийн гадуурх зарцуулалт”, мөн Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг боловсронгуй болгоход чиглэсэн “Шилэн дансны тухай хууль, журмын чиглэлээр Төрийн аудитын байгууллагаас гаргасан дүгнэлтүүдэд үндэслэсэн эрх зүйн судалгаа”, Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлогод хийсэн хөндлөнгийн тойм дүгнэлт” зэрэг шинжилгээ судалгааг хийлээ.

Улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бодлогоо хэрэгжүүлэхдээ төсвийн нэгдмэл байдлыг хангах нь чухал талаар олон улсын байгууллагуудаас Засгийн газарт зөвлөдөг. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд Засгийн

газрын төсвийн гадуурх зарцуулалт байнга нэмэгдэж байна. Тухайлбал, ахмадын тэтгэврийн зээлийг тэглэх, нүүрсний экспортыг дэмжих зорилгоор төмөр зам барих, цар тахлын үеэр иргэдэд мөнгөн дэмжлэг олгох зэрэг үйл ажиллагааг улсын нэгдсэн төсөвт тусгаагүй. Энэ талаарх нарийвчилсан судалгааг Г.Дэлгэрмаагаар ахлуулсан судалгааны баг хийж гүйцэтгэлээ. Мөн төрийн аудитын байгууллагаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд жил бүр аудит хийн уг хууль болон бусад журмын хийдэл, давхардал, уялдаагүй байдлыг засаж залруулах, өөрчлөх зөвлөмжийг удаа дараа холбогдох байгууллагуудад хүргүүлж ирсэн. Иймд энэхүү хууль, журмыг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах үүднээс ННФ-ын дэмжлэгтэйгээр Шилэн дансны тухай хууль, журмын чиглэлээрх хууль, эрх зүйн судалгааг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяраар ахлуулсан баг хийж гүйцэтгэлээ.



- Уул уурхайн салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудаас Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөр дамжуулалгүй гаргасан зардлын дотор иргэдийн цахилгаан, дулааны 1.1 их наяд төгрөг, мөн сайжруулсан түлшийг 75 хувиар хямдруулсан зардал багтаж байна.
- Судалгаагаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Төрийн аудитын байгууллагаас 2015-2019 онд хийсэн аудитын тайлангуудад үндэслэн холбогдох хууль болон шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг боловсронгуй болгоход чиглэсэн зөвлөмжүүдийг боловсруулав. Дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу.

“КОВИД-19” цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын ДНБ-ийн хэмжээ 2020 онд өмнөх оноос нэг хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит дүнгээр 4.6 хувиар агшжээ<sup>3</sup>. Тиймээс Засгийн газраас ажилгүйдэл, ядуурал өсөх эрсдэл өндөр байгааг харгалзан эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв, санхүүгийн бодлого хэрэгжүүлэхээр “Шинэ сэргэлтийн бодлого”-ын

хөтөлбөр боловсруулан 2021 оны 12 дугаар сард УИХ-аар хэлэлцүүлж батлуулахаар өргөн барьсан билээ. Судлаач А.Батпүрэв уг хөтөлбөрт тусгасан бодлогуудын оновчтой байдал болон төсөв, мөнгөний бодлогын зарчмуудтай хэрхэн үялдаж буйг шинжлэн судаллаа. Мөн уг хөтөлбөрийг олон улсын ижил төстэй бодлого, хөтөлбөртэй харьцуулан авч үзэж, хөндлөнгийн дүгнэлт гарган, бодлогын зөвлөмж боловсрууллаа.

<sup>3</sup> Үндэсний статистикийн хороо (2021), Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2020.

## Төсвийн зөвлөл



ННФ-ын дэргэдэх Төсвийн зөвлөлийн хурлын явцаас, 2021 оны 3 дугаар сар.

Төрийн зүгээс төсөв, санхүүд тавих хяналтаа сайжруулах, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлого шийдвэрт иргэдийн дуу хоолойг тусгах ажилд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ННФ-аас санаачлан 2021 оны 3 дугаар сард “Төсвийн Зөвлөл”-ийг байгуулан ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд “Төсвийн Зөвлөл” нь улсын төсөв, санхүүгийн асуудлуудаар хэлэлцэн бодлогын шинжилгээ хийж үр дүнг бодлого боловсруулагчид, олон нийтэд хүргэх ажлыг хийлээ. Тухайлбал, төсвийн гадуурх зарцуулалт, Ковид-19 цар тахлын эсрэг төсвийн бодлого зэрэг сэдвээр хэлэлцүүлэг хийн үр дүнг “Төсвийн шинжилгээ” цувралуудад нийтлэн олон нийтэд хүргэлээ. Дүн шинжилгээнд үндэслэн УИХ, Засгийн газар, Сангийн яам болон төрийн холбогдох бусад байгууллагад хандан санал, зөвлөмж гаргасан юм.

**“Төсвийн Зөвлөл” нь нийтийн сан хөмрөгийн оновчтой зарцуулалтыг дэмжих зорилгын дор хараат бус шинжээчдээс бүрдэн байгуулагдсан бөгөөд уг үйл ажиллагаанд иргэд мэдээлэлтэй оролцох, хяналт тавих боломж нөхцөлийг нэмэгдүүлэхийг чухалчлан ажиллаж байна.**



Уг Зөвлөлийн үйл ажиллагаагаар иргэний нийгмийн зүгээс хийх төсвийн дүн шинжилгээ тогтворжиж, төсвийн чиглэлээрх цаг үеийн асуудлуудад анализ бүхий шуурхай хариу үзүүлдэг болох, төсвийг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулах, оновчтой зарцуулалт бий болгоход хувь нэмэр оруулна хэмээн үзэж буй.

## ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Н.Энхбаяр, Эдийн засагч  
 Н.Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Монгол Улс дахь менежер  
 А.Батпүрэв, “Санхүүгийн хүртээмж-хөгжил” ТББ-ын үүсгэн байгуулагч, гишүүн  
 Л.Болормаа, Санхүүч, “BFAS” санхүүгийн зөвлөх үйлчилгээний компанийн Гүйцэтгэх захирал  
 С.Боргил, Санхүүч, “Сэргэлт Консалтинг Групп” компанийн захирал

Г.Бумчимэг, Банк Санхүүгийн Академийн Гүйцэтгэх захирал  
 Ц.Мөнхбаяр, Эдийн засагч, санхүүч, Байэр Адвайзори ХХК-ийн зөвлөх  
 П.Эрдэнэжаргал, Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  
 Д.Оюунбадам, Төсвийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер



*Төсвөөс гадуурх зарцуулалт"-ын шинжилгээгээр төсвийн тогтвортой, иж бүрэн, ил тод байдлыг бүрэн хэмжээнд хангах, сахилга батыг дээшлүүлэх үүднээс төсвийн гадуурх зарцуулалтыг бодлогын хүрээнд оновчтой зохицуулж, аль болох ийм зардал гарахыг хязгаарлах талаар санал, зөвлөмж гаргав. Харин "Ковид-19 цар тахлын эсрэг төсвийн бодлого" шинжилгээгээр цар тахлын эсрэг төрийн байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн төсвийн бодлогын явц, үр дүнг үнэлэн цаашид хэрэгжүүлэх бодлогыг нээлттэй хэлэлцэх, төсвийн хүрээнд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг урт хугацаанд, цогцоор авч үзэж, зарцуулалтын тайлагнал, ил тод байдлыг сайжруулах талаар санал, зөвлөмж гаргалаа. Мөн Ковид-19-тэй холбоотой урсгал болон хөрөнгийн зардлыг бүх шатанд ойлгомжтой бүртгэж, хянах аргачлалыг төсвийн журамд оруулах, шилэн дансаар ил болгохыг санал болгожээ. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.forim.mn](http://www.forim.mn) сайтаас харна уу.*

Түүнчлэн Төсвийн зөвлөл нь "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль" болон "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилт, 2021 оны төсвийн тодотголын асуудлыг хэлэлцэн УИХ-д санал, зөвлөмж хүргүүллээ. Уг санал, зөвлөмжид Засгийн газар иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад гол анхаарлаа хандуулан санхүүгийн нөөцөө зарцуулах, хөтөлбөрийн зардал, санхүүжилтийг илүү тодорхой болгох, цар тахалтай тэмцэх болон төсвийн хуулийн зөрчлийг аль болох яаралтай авч үзэх,

Монгол Улсын 2021 оны төсөвт тодотгол хийх зэрэг асуудлыг тусгасан юм.

Цаашилбал Төсвийн зөвлөл нь Уул уурхай хүнд үйлдвэрлэлийн яамнаас боловсруулсан Үндэсний баялгийн сангийн тухай болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төслүүдийг ННФ-ын "Байгалийн баялгийн засаглал" хөтөлбөртэй хамтран хэлэлцэв. Хэлэлцүүлгийн дүнд эдгээр хуулийн эрх зүйн орчин, зорилго, макро эдийн засгийн үялдаа холбоо, институцийн тогтолцоо, засаглалын бүтэц, хөрөнгө оруулалт болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны чиглэлээр зөвлөмж гарган тус яаманд хүргүүллээ.



## Улсын төсвийн бодлогын түвшний оролцоо

Төсвийн төлөвлөлт, төсөвт тавих хяналт, түүний ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, баримт бичиг боловсруулах ажилд ННФ-ын зүгээс төрийн байгууллагуудыг судалгаа, шинжилгээ, мониторингийн үр дүнгээр хангахаас гадна шаардлагатай тохиолдолд бусад бие даасан судлаач, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хууль тогтоомж, дүрэм журмын төсөлд бодлогын чанартай санал зөвлөмж хүргүүлж ирлээ. Тухайлбал, нийтийн төсөвт тавих төрийн хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр хууль боловсруулахад оролцон УИХ-ын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Ажлын дэд хэсэгт багтаж ажиллалаа. Ингэснээр уг хуулийн нийтийн төсөв, санхүүгийн удирдлагад хяналт тавих зохицуулалтуудыг боловсронгуй болгоход чиглэсэн саналаа хүргүүлэв. Үүнд, УИХ-ын хяналтыг хэрэгжүүлэхэд УИХ дахь цөөнхийн оролцоог нэмэгдүүлэх, УИХ-ын хяналтаас гарах үр дүнг тодорхой болгох, УИХ-ын хяналтын ил тод байдал, хяналт дахь иргэдийн оролцоог хангах, УИХ-аас нэгдсэн төсвийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх хугацааг тодорхой заах, нэгдсэн

төсвийн төсөлд иргэний нийгмийн зүгээс УИХ-д хүргүүлсэн саналын шийдвэрлэлтийн талаар тайлагнах зэрэг зарчмын асуудлууд багтсан болно. Энэ нь олон улсад тогтсон сайн жишиг юм. Уг хууль 2021 оны 12 дугаар сард батлагдлаа.

Засгийн газраас Төсвийн тухай хуулийн 29.4 заалт дахь "...төслүүд нь зураг төсвөө батлуулсан байх" шаардлагыг хангахгүй барилга байгууламжийг эхлүүлэх ажлыг төсөвт суулган УИХ-аар батлуулж буй нь төсвийн хөрөнгө оруулалттай төслийн хэрэгжилт удааширч байгаагийн нэг гол шалтгаан юм. Тиймээс ННФ-ын зүгээс хуулийн шаардлага хангасан төслүүдийг л төсөвт тусгах шаардлагатайг "Бодлогын асуудал" цувралынхаа 32 дахь дугаарт хөндсөн юм. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар 2019 онд шинээр эхлүүлэхээр баталсан зураг, төсөв шаардлагатай 638 төсөл, арга хэмжээний 84.3 хувь нь хуулийн шаардлага хангаагүй байсан бол 2021 оны төсвийн төсөлд шинээр эхлүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдээс мөн л 55 нь зураг, төсөвгүй байжээ.



Энэхүү шинжилгээнд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл удааширснаар төсөв үр ашиггүй зарцуулагдаж буйг хөндөхийн зэрэгцээ төсвийн төлөвлөлтийн баримт бичгийн иж бүрдэл, мэдээллийг нээлттэй болгох, баримт бичгийн агуулгад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулж орууллаа. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.fogim.mn](http://www.fogim.mn) сайтаас харна уу.

Мөн “Монгол Улсын төсвийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсронгуй болгох асуудалд” нийтлэлийг “Бодлогын асуудал” цувралынхаа 33 дугаараар бодлого боловсруулагчдад хүргэлээ. Нийтлэлд улсын төсвийн хөрөнгө оруулалттай зарим төслийн хэрэгжилт удааширч, төсөвт өртөг нь харилцан адилгүй өссөнөөр төсөв үр ашиггүй зарцуулагдаж байгааг хөндлөө. Тэрчлэн шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь заалтын дагуу олгохгүй, эхний жилд нь хэт бага төсөв төлөвлөж тэр нь барилгын шав тавихаас хэтрэхгүй ажил цөөнгүй байгааг мөн дурдлаа. Засгийн газраас боловсруулсан хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад нийт төсөвт өртгийн хэдэн хувийг эхний жилд санхүүжүүлж байгааг харуулдаггүйгээс бодлого боловсруулагчид уг төслүүд Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад нийцсэн төлөвлөлт эсэхийг хянаж шалгах боломжгүй болдог аж. Үүний оронд зөвхөн тухайн жилийн санхүүжилтийн мөнгөн дүнг харуулсан мэдээлэл л ирдэг байна. Мөн шилжих төслүүдийн хувьд зөвхөн өргөн барьж буй төслийн төсөвт өртгийг л харуулахаас тухайн төслийн анх батлагдсан төсөвт өртгийн мэдээллийг багтаадаггүй зэрэг асуудлыг энэхүү “Бодлогын асуудал”-аар хөндөж гаргасан болно.

Ийнхүү хөрөнгө оруулалтын шинэ болон шилжих төслүүдийн мэдээллийн иж бүрдэл хангалтгүй байгаа нь УИХ-ын гишүүд бүрэн мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломж нь хязгаарлагдаж буйг шийдвэрлэх арга замыг зөвлөмжид дурдаж орууллаа. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын

одоогийн маягтад эдгээр мэдээллийг тусган шинэчлэх; батлагдсан төсөл, арга хэмжээнд дахин давтагдахгүй код олгох; төсвийн тодотгол хийгдэх тохиолдолд тусгайлсан маягт боловсруулах нь зүйтэйг мөн тусгалаа. Мөн улсын төсвийн төслийн баримт бичгийн болон баталсан төсвийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг “Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа”-наас гаргасан зөвлөмжийн дагуу тус тус сайжруулахыг зөвлөмж болгов. Эдгээр санал зөвлөмжөөс Монгол Улсын Нээлттэй Засгийн Түншлэлийн 2022-2023 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд тусгах чиглэлээр бид мөн ажиллалаа.

Ийнхүү иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс дүн шинжилгээнүүддээ тулгуурлан бодлого боловсруулагчдад хандсан санал, зөвлөмж боловсруулахаас гадна төсвийн холбогдох хууль, тогтоомжийг УИХ-аар хэлэлцэх явцад анхаарах асуудлуудыг хөндөн, санал боловсруулан төрийн байгууллагуудад хүргүүлж, төсвийн асуудлаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэл хүргэж ажилласны дүнд Монгол Улсын төсвийн ил тод байдал, тайлагнал, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чиглэлээр зарим ахиц гарлаа. Тухайлбал, 2022 оны улсын төсвийн төсөлд туссан шинээр эхлэх барилга байгууламжуудын нэгээс бусад нь зураг, төсөвтэй байсан нь өмнөх жилүүдээс эрс сайжирсан үзүүлэлт байлаа. Энэ нь иргэний нийгмийн зүгээс хийсэн ажиглалт, судалгааны дүнд Засгийн газар анхаарал хандуулан Төсвийн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангахад ахиц гаргасныг харуулж байна.

## Төсвийн асуудлаарх олон нийтийн үйл ажиллагаа

Төсвийн ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах асуудлуудаар бодлогын түвшинд нөлөөллийн ажил хийхээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл хүргэх, зарим төрийн байгууллагын хурал, зөвлөгөөнд илтгэл тавих хэлбэрээр хамтран ажиллаж ирлээ. Тухайлбал, 2021 оны 12 дугаар сард болсон Авлигын эсрэг үндэсний чуулганд ННФ-ын хөтөлбөрийн менежер “Монгол Улсын төсвийн ил тод байдал, зарцуулалтад иргэний нийгмийн зүгээс тавих хяналт, анхаарах асуудал” илтгэл танилцуулаа. Уг

илтгэлийг “Төрийн албаны шударга, ил тод байдлыг бэхжүүлэх нь” салбар хуралдаанд танилцуулсан бөгөөд түүнд төсвийн төлөвлөлтийг сайжруулах, төлөвлөлтийн баримт бичгийн агуулгад тавигдах шаардлага, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бүртгэлийг боловсронгуй болгох, төсвийн төслийн баримт бичгийн болон УИХ-аас баталсан төсвийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулах зэрэг санал зөвлөмж багтсан юм.




Авлигын эсрэг үндэсний чуулганы үеэр ННФ-ын Хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам танилцуулга хийж буй нь, 2021 оны 12 дугаар сар.

Түүнчлэн уг илтгэлд Шилэн дансны нэгдсэн системийг нээлттэй өгөгдлийн зарчмаар шинэчлэн, төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг турших, эмзэг болон төлөөлөл багатай бүлгийг төсвийн хэлэлцүүлэгт татан оролцуулах, УИХ-аас олон нийтийн эсвэл иргэний нийгмийн байгууллагын

төлөөлөгч төсөв батлагдахаас өмнөх хэлэлцүүлгийн болон аудитын тайлан сонголд оролцож мэдүүлэг өгөх боломж бүрдүүлэх хэрэгтэй байгааг тэмдэглэлээ. Үндэсний аудитын газар аудитын үйл явцдаа олон нийт оролцох албан ёсны механизм бий болгох хэрэгтэй байгаа талаар мөн танилцуулгадаа дурдсан юм.

ННФ Монгол Улсын хувьд тулгамдаад буй Нийгмийн даатгалын сангийн тогтолцоог шинэчлэх асуудалд хувь нэмэр оруулахыг зорьж өнгөрсөн онд “Нийгмийн даатгалын сангийн 2012-2020 оны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын дүн шинжилгээ: Сангийн удирдлагыг боловсронгуй болгох талаарх санал зөвлөмж” судалгааг санхүүжүүлж хийлгэсэн юм. Уг судалгааны дүнг танилцуулах уулзалт 2021 оны 3 дугаар сард болж уг уулзалтад судлаачид, иргэний нийгмийн төлөөллөөс гадна Нийгмийн даатгалын Ерөнхий газрын дарга Д.Зоригт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Батжаргал нар оролцов.



“Нийгмийн даатгалын сангийн төсвийн шинжилгээ: Сангийн удирдлагыг боловсронгуй болгох талаарх санал зөвлөмж” судалгааны дүнг танилцуулах цахим уулзалтын явцаас, 2021 оны 3 дугаар сар.




ННФ-ын Хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам Eagle, Bloomberg телевизүүдээр Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн анхаарах асуудлуудыг хөндлөө. 2021 оны 11 дүгээр сар.

Монгол Улсын 2022 оны төсвийн төсөл хэлэлцэж буйтай холбогдуулан 2021 оны 11 дүгээр сард зарим анхаарах асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэл хүргэлээ. Ийнхүү мэдээлэл хүргэх явцаа бид өмнөх онуудад байнга давтагдаж, төсвийн судалгаа шинжилгээгээр чухалчлан зөвлөж байсан, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төслийн эхний санхүүжилтийг мөн л Төсвийн тухай хуульд зааснаас бага хэмжээгээр тусгасан, зарим шилжих төслийн төсөвт өртөг ихээхэн өссөн, төсвийн орлогыг хэт өөдрөгөөр төсөөлсөн зэрэг асуудлуудыг хөндлөө. Төсөв боловсруулах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион

байгуулагдаж буй “Ирээдүйгээ төсөвлө” таван сарын аяны хүрээнд онлайн хэлэлцүүлэгт оролцсоноос гадна ННФ-ын Хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам “Иргэдийн оролцоо: Улсын төсвийн үйл явцад хяналт тавьж, саналаа оруулах нь” нийтлэл гаргалаа. Энэхүү аяныг Сангийн Яамнаас Unread Media компанитай хамтран 2021 оны 12 дугаар сараас эхлүүлсэн юм. Уг аянаар дамжуулан олон нийтэд төсвийн тухай энгийн ойлголтоос эхлээд Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын үйл явцад хэрхэн оролцож болох тухай өргөн хүрээний мэдээлэл хүргэхээр ажиллаж байна.

## Төсвийн асуудлаарх олон улсын хамтын ажиллагаа



Олон улсын төсвийн түншлэл ([www.internationalbudget.org](http://www.internationalbudget.org)) байгууллагаас хоёр жил тутамд эрхлэн гаргадаг “Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа”-ны Монгол Улсын үнэлгээг бид хийж гүйцэтгэн,

үр дүнг нийтэд танилцуулан ажилласны дүнд Сангийн яамнаас иргэдийн төсвийг тогтмол нийтлэх болсноос гадна төсвийн хагас жилийн тайланг нийтэлсэн ахиц дэвшил 2021 онд гарлаа. Энэхүү тайланд төсвийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл багтсан боловч төсөв боловсруулахад ашигласан эдийн засгийн урьдчилсан нөхцөлийг нягталсны үндсэн дээр хийгддэг төсвийн хүлээгдэж буй үр дүнгийн талаарх шинэчилсэн таамаглал багтаагүй байна. Иймд олон улсын сайн туршлагын дагуу төсвийн оны эцсээрх хүлээгдэж буй гүйцэтгэлийн талаарх шинэчилсэн таамаглалыг багтаадаг болох нь зүйтэй юм.

Түүнчлэн Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас зохион байгуулдаг “Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа” дахь Монгол Улсын ээлжит судалгааг 2021 онд хийж гүйцэтгэлээ. Уг судалгаагаар төр засгийн зүгээс улсын төсвийн үндсэн баримт бичгүүдийн мэдээллийг иж бүрэн, шуурхай ил болгосон эсэх, төсвийн үйл явцад иргэд оролцох боломжтой байсан эсэх, мөн төрийн хяналтын байгууллагуудын зүгээс төсөвт тавих хяналтын түвшинд гарч буй өөрчлөлтийг дэлхийн 100 гаруй оронтой харьцуулан үнэлж үр дүнг нийтэд зарладаг билээ. Түүнчлэн эдгээр үзүүлэлтийг өнөөгийн түвшнээс хэрхэн дээшлүүлэх чиглэлээр зөвлөмж гаргадгаараа ихээхэн ач холбогдолтой. Энэхүү ээлжит судалгааны дүнг дэлхий даяар 2022 онд танилцуулах юм.



Олон улсын төсвийн түншлэл байгууллагатай өрнүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд бид “Төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэл ба Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт” судалгааг хийж байна. Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд улс орнууд санхүүгийн нөөцөө хүртээмжтэй өсөлтийг дэмжих, нийгмийн эмзэг бүлэгт хүргэх үйлчилгээг сайжруулахад илүүтэй чиглүүлэх хэрэгтэй талаар олон улсын судлаачид зөвлөдөг. Засгийн газар нийтийн баялгийг төсвөөр дамжуулан үр дүнтэй хуваарилж, зарцуулах нь Тогтвортой хөгжлийн зорилтуудад 2030 он гэхэд хүрэх явдлыг түргэсгэхэд чухал юм. Төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн зөрүү нь иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх, ядуурлыг бууруулах зорилгодоо улс орнууд хүрэхэд нөлөөлөх чухал үзүүлэлт болно. Иймд бид Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн зөрүүг салбараар судалж байна. Энэхүү судалгааны дүн ирэх онд дэлхий даяар танилцуулагдана.



Монгол Улсын Нээлттэй Засгийн Түншлэл (НЗТ)-ийн 2022-2023 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө боловсруулахад ННФ-ын төлөөлөл оролцон улсын төсөв, төсвийн хөрөнгө


оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээрх зорилтыг Сангийн яамтай хамтран боловсрууллаа. Уг төлөвлөгөөний зургаадугаар зорилтод Засгийн газрын зүгээс хэрэгжүүлэх арга



хэмжээний хүрээнд төсвийн үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай, иж бүрэн байдлыг хангах зохицуулалтуудыг төсвийн хууль тогтоомжид оруулах, үүний дотор Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн журамд ННФ-ын “Бодлогын асуудал”-аар зөвлөмж болгосон зарим зохицуулалтыг нэмж тусгахаар болсон юм. Үүнд (i) Улсын төсвийн хөрөнгөөр шинээр эхлэх төслүүдийн хувьд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний маягтад “тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг нийт төсөвт өртөгт эзлэх хувиар”, шилжих төслүүдийн хувьд “анх батлагдсан төсөвт өртөг” зэрэг мэдээллийг нэмэх; (ii) Төсвийн тодотгол хийгдэхэд УИХ-д өргөн баригдах хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтын тусгайлсан маягтуудыг боловсруулах. Түүнчлэн уг төлөвлөгөөнд Шилэн дансны нэгдсэн системийг НЭТ-ийн Үндэсний 4-р төлөвлөгөө хэрэгжих хугацаанд иж бүрэн шинэчлэх болон улсын төсвийн үйл явц, хөрөнгө оруулалт, зарцуулалт тусгай сангууд, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын талаар иргэд, олон нийт, татвар төлөгчид жилийн турш саналаа өгч хэлэлцүүлэг өрнүүлж байх цахим талбарыг бий болгох амлалтууд тусгагдлаа.

Бид Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ)-тай түншлэн жил бүр Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн ([www.weforum.org/gcr](http://www.weforum.org/gcr)) Монгол Улсын Бизнесийн удирдах ажилтнуудын санал асуулгын судалгаа хийж, Өрсөлдөх чадварын индексийн дүнг нийтэд танилцуулж ирлээ.

Улс орны бүтээмж нь түүний хүрч чадах хөгжлийн түвшнийг тодорхойлдог. Тухайн улсын бүтээмжид нөлөөлөгч гол хүчин зүйлүүдийн үнэлгээнд үндэслэн Өрсөлдөх чадварын индексийг гаргадаг.



*Нээлттэй Засгийн Түншлэлийн 2022-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний улсын төсөвт иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээрх зорилтыг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон Сангийн яамтай хамтран боловсруулах уулзалтын явцаас, 2021 оны 11 дүгээр сар.*

2021 онд хийсэн ээлжит судалгааны дүнд 2022 онд дэлхий даяар танилцуулагдана. Монгол Улс 2005 оноос энэхүү тайланд нэгдэж, өрсөлдөх чадварын түвшнээ дэлхийн 140 гаруй оронтой харьцуулан харах боломжтой болсон. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тус тайлангийн дүнг улс орнууд анхааралтай авч үзэж бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлдэг. Иймээс Монгол Улс энэхүү судалгааны дүнд анхаарал хандуулж ажиллах нь манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дээшлүүлэхэд ач холбогдолтой юм.

## ТӨСВИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ННФ иргэний нийгмийн хамтын ажиллагааны хүрээнд улс, орон нутгийн төсвийн зарлага, худалдан авалтад дүн шинжилгээ хийн олон нийтэд хүргэх, төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, төсөвт залуусын хяналтыг

нэмэгдүүлэх зорилгоор сонирхолтой үйл ажиллагаа өрнүүлэх, аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд чиглэсэн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд төрийн бус байгууллагуудын идэвхтэй оролцоог хангаж ажиллалаа.

### Мониторинг, нийтийн сонсгол

Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд төсвийн мониторингийн дүнд үндэслэн 2021 онд Говь-Алтай, Өвөрхангай аймгийн төвүүд болон зарим сумдад, мөн нийслэлийн Багануур дүүрэгт нийт зургаан удаа төсвийн сонсгол зохион байгууллаа. Тухайлбал, Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ-ын Өвөрхангай аймаг

дахь салбар Өвөрхангай аймгийн Хужирт, Бүрд суманд; Эх Нутаг Хөгжил төв ТББ Баянгол, Хайрхандулаан сумдад сум тус бүрийн ИТХ-тай хамтран "Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн зарцуулалт, гүйцэтгэл"-ийн хяналтын сонсголыг 2021 оны ес, арав дугаар сард тус тус зохион байгууллаа.



Өвөрхангай аймгийн сумдад хийсэн төсвийн сонсголын явцаас, 2021 оны 9-10 дугаар сар.  
Бүрд, Хужирт сум дахь сонсголын явц  
Баянгол сум дахь сонсголын явц



“Говь-Алтай аймгийн иргэний нийгмийн нэгдсэн зөвлөл” ТББ Говь-Алтай аймгийн төв болон Есөнбулаг сумын “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019, 2020 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн”-гээр төсвийн хяналтын сонсголыг сумын ИТХ-тай хамтран 2021 оны 9 дүгээр сард, аймгийн ИТХ-тай хамтран 2021 оны 10 дугаар сард тус тус зохион байгуулав.

Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ-ын Багануур дүүрэг дэх салбар дүүргийн ИТХ-тай хамтран Багануур дүүргийн 2021 оны худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт болон тендер сонгон шалгаруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын төсвийн хяналтын сонсголыг 2021 оны 11 дүгээр сард зохион байгуулахдаа Ковид-19 цар тахлын нөхцөл байдлыг харгалзан уг сонсголд танхимаар болон цахимаар оролцох боломжийг иргэдэд олгосон байна.



Багануур дүүрэгт зохион байгуулагдсан төсвийн хяналтын сонсголын явцаас 2021 оны 11 дүгээр сард.

“Захиргааны Шинэ Санаачилга” ТББ-аас дараах чиглэлээр мониторингийн төсөл хэрэгжүүллээ. Үүнд:

- “КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 15.1-р зүйлийн хэрэгжилтийн мониторингоор Эрүүл мэндийн яам, Нийслэлийн онцгой комисс, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гадаад харилцааны яам зэрэг хандив тусламж хүлээн авсан байгууллагуудын шилэн дансанд ажиглалт хийв. Мөн дотоодын хандив, тусламжийн мэдээллийг эрүүл мэндийн салбарын байгууллагууд шилэн дансандаа байршуулсан эсэхийг ажиглав. Мониторингийн хүрээнд зөвхөн ажиглалт хийгээд зогсохгүй хандив, тусламжийн мэдээллийн ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулснаар зарим

байгууллага тайлангаа шилэн дансанд нөхөн нийтэлжээ.

- Засгийн газраас гаргасан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг tender.gov.mn сайт дээр ажиглалаа. Зөвхөн 2021 оны 11 дүгээр сарын төрийн худалдан авалтыг ажиглахад л уг тогтоолыг зөрчин худалдан авалт хийж байгаа нь харагдсан тул Төрийн худалдан авалтын газарт энэ талаар мэдээлж, Авлигатай тэмцэх газарт зарим худалдан авалтын баримт бичгүүдийг хүргүүлээд байна.

Түүнчлэн “Үнэн хатамж” ТББ төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийж, үр дүнгээ ННФ-ын “Монитор цуврал”-ын 30 дугаарт нийтлэн олон нийтэд хүргэлээ.



*Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийг аудитын төрлөөр авч үзэхэд санхүү дээр харьцангуй сайн, харин нийцлийн болон гүйцэтгэлийн аудит дээр сул байв. Харин хэрэгжүүлэгчээр нь авч үзэхэд төсвийн шууд захирагчид зөвлөмжийг харьцангуй сайн дагаж мөрдөж байхад төсвийн ерөнхийлөн захирагчид анхаарахгүй байгаа нь ажиглагдав (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).*

Цаашилбал Ховд аймгийн “Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ тус аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэдэх 50 ортой Хүүхдийн эмнэлгийн чанаргүй барилгын асуудлыг хөндөн нийтийн эрх ашгийн өмгөөлөл явууллаа. Тус байгууллага холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах, гүйцэтгэгч барилгын компаниар хүүхдийн эмнэлэгт засвар

хийлгүүлэх нэхэмжлэлийг шүүхэд гарган, уг асуудалтай холбоотой нийтлэл бичиж цахимаар олон нийтэд түгээв. Эдгээр ажлын үр дүнд зөрчилтэй асуудал олны анхааралд орж уг барилгын ажлыг гүйцэтгэсэн компани зарим засварын ажлыг хийсэн боловч одоогоор алдаа дутагдлаа бүрэн гүйцэд арилгаагүй байна.



## Бүс нутгийн санаачилга ба Монгол Улс

Бүс нутгийн санаачилгуудын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлэх төслүүдийн мэдээлэл, санхүүжилтийн нөхцөл, Монгол Улсад үзүүлэх нөлөөллийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор нийтэд мэдээлэл хүргэх, судалгаа шинжилгээний ажлыг судлаачид хийж эхлээд байна. Тухайлбал, бүс нутгийн хэмжээнд Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (АДБХОБ) байгуулагдаж, БНХАУ-ын санаачилгаар “Бүс ба Зам” зэрэг томоохон төслүүд хэрэгжин энэ санаачилгын хүрээнд БНХАУ олон оронд хөрөнгө оруулалт хийж байгаа юм. Монгол Улс эдгээр санаачилгад нэгдэн зарим төслийг хэрэгжүүлэхээр зээлийн хэлэлцээр байгуулан санхүүжилт авахаар болж байгаа тухай зарим мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдээд буй. Хэдий тийм боловч уг

төслөөр санхүүжин Монгол Улсад хэрэгжих ажлууд, зээл, тусламжийн мэдээлэл нээлттэй биш байна.

Гадаад эх сурвалжаас харахад “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд Монгол Улс нийгмийн кредит онооны системд нэгдэн царай таних камер ашиглахаас гадна төмөр зам, харилцаа холбоо, эрчим хүчний зэрэг төслүүдэд зээл, тусламж авах мэдээлэл байгаа юм. Иймд “Бүс ба Зам”, АДБХОБ-ны санхүүжилтээр хэрэгжих Монгол Улсад хамаарал бүхий төслүүд, тэдгээрийн нөлөөлөл, манай улсад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болон хэрэгжиж буй төслүүдийн судалгаа хийх, эдгээр санаачилгын засаглалын зарчмуудыг судлах ажлыг доктор Д.Төмөрпүрэв, судлаач С.Боргил нар хамтран гүйцэтгэж байна. Түүнчлэн [itoim.mn](http://itoim.mn) сайт бүс нутгийн санаачилгын талаар олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

## Хакатон

Орон нутгийн төсөвт иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор Бодлогод залуусын хяналт ТББ-аас “Орон нутгийн төсвөө хянацгаая!” хакатоныг ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс болон Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ-тай хамтран

2021 оны есдүгээр сард зохион байгууллаа. Энэхүү хакатонгоор асуудал дэвшүүлсэн сэтгүүл зүйн бүтээл туурвих замаар төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх шийдэл санал болгохыг зорьсон юм. Хакатонд нийт 20 гаруй оролцогч хамрагдлаа.



“Орон нутгийн төсвөө хянацгаая!” хакатонд оролцогчид, 2021 оны 9 дүгээр сар.



Хакатоны хүрээнд Орон нутгийн төсөв болон худалдан авах ажиллагаа дахь иргэдийн оролцоо, хяналт тавих боломжууд, Төсвийг иргэдийн нүдээр харах нь (сайн түршлага), Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчлэлийн асуудал, Асуудал дэвшүүлсэн өгүүлэл бичих арга, дүн шинжилгээгээ бүтээгдэхүүн болгоход юу анхаарах зэрэг сэдвээр лекц, семинар

зохион байгуулав. Хакатоны үйл ажиллагаанд Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ц.Батзул, Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа, Бодлогод залуусын хяналт ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга Т.Энхжаргал, Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төлөө төвийг төлөөлөн Ц.Чимэддондог, Үнэн хатамж ТББ-ын захирал Ж.Сайнзаяа, ННФ-ын Хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нар оролцон илтгэл, танилцуулга хийлээ.



Хакатоны зочин багш Ч.Болортуяа (Ерөнхий сайдын зөвлөх), Ж.Сайнзаяа (Үнэн хатамж ТББ) нар танилцуулга хийж буй нь, 2021 оны 9 дүгээр сар.

Уг арга хэмжээний үр дүнд залуучууд мэргэжлийн зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр орон нутгийн төсөвт дүн шинжилгээ хийх арга зүйд суралцсан юм. Мөн орон нутгийн төсвийн зарцуулалт тэр дундаа үр ашиггүй зарцуулалтын мэдээллийг иргэдэд ойлгомжтой, энгийнээр илэрхийлэн гаргасан “Ковидын төсөвт иргэд эргэлзэж байна”, “Төр хүүхэд, залууст төсөөллийн

тоглоомын талбай барьж өгдөг үү?”, “Хариуцах эзэнгүй эвдэрсэн замаа эзэнтэй болгоё!” зэрэг сэтгүүл зүйн бүтээл бэлтгэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээв (Дэлгэрэнгүйг дараах линкээр орж үзнэ үү <https://www.facebook.com/YouthPolicyWatch/videos/229243082551978>).


## ХАКАТОНЫ БАГУУДААС ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ГАРГАСАН СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛҮҮД



### Төрийн хяналтын байгууллагатай өрнүүлсэн хамтын ажиллагаа

Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд ННФ төрийн хяналтын байгууллагуудтай түншилж ирсний дотор Үндэсний Аудитын газартай 2018 оноос эхлэн амжилттай хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитад иргэний нийгмийн шинжээчид оролцон ажилласнаас гадна төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг энгийн, ойлгомжтой хэлбэрээр олон нийтэд хүргэн, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажилласан юм. Үндэсний Аудитын газраас аудитын дүн мэдээг нийтэд хүргэх ажлыг тогтмолжуулах үүднээс ажилтнуудаа инфографик боловсруулах сургагч-багш

бэлтгэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулав. Энэхүү сургалтын үеэр ННФ-аас “Төрийн аудитын дүнгээр инфографикийн агуулга боловсруулах нь” сэдвээр танилцуулга хийлээ. Мөн ННФ-аас 2021 оны 10-11 дүгээр сард сургалтад оролцогсодод 2021 онд гарсан “Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”, “Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бүүруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө” аудитын тайлангуудаар инфографик багцын агуулга бэлтгэх дадлага ажлыг зохион байгууллаа.



Түүнчлэн ННФ-аас “Төрийн аудитын байгууллага болон иргэний нийгмийн байгууллагын улсын төсвийн чиглэлээрх хамтын ажиллагаа” сэдэвт танилцуулгыг Үндэсний Аудитын газраас сэтгүүлчдэд зориулан 2021 оны 12 дугаар сард зохион байгуулсан “Мэдлэг хуваалцах цаг” арга хэмжээний үеэр хийлээ. Энэхүү арга хэмжээг цаашид төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийн талаар олон

нийтэд үнэн зөв бодит мэдээлэл өгөх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийг чадавхжуулахад чиглүүлэн цувралаар зохион байгуулах юм. Мөн ННФ-ын дэмжлэгтэйгээр төрийн аудитын байгууллагаас олон нийтэд төрийн аудитын байгууллага, аудитын төрөл, үйл ажиллагаанд иргэд хэрхэн оролцох талаар мэдээлэл өгөхөөр богино хэмжээний видео контентуудыг боловсруулж байна.

## ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ НЬ

Монгол Улс 2019 онд хүн төрөлхтний орчин үеийн хөгжлийн чиг хандлага болох тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг Үндсэн хуульдаа тунхаглан баталгаажуулж, байгалийн баялгаа урт хугацааны бодлогоор ашиглах, одоо ба ирээдүй үеийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, мэдэх эрхийг нь ханган үр өгөөжийг нь тэгш шударга хүртээх эрх зүйн үндсийг тогтоосон билээ. Үндсэн хуулийн энэхүү үзэл баримтлалд нийцүүлэн салбарын хууль тогтоомжийг шинэчлэх ажлын эхлэлийг тавих үйл явц өнгөрсөн онд нэлээд эрчимжив.

Цар тахлын дэгдэлтээс улбаалан олборлолт буурч, экспортын тээвэр удаашран 2021 оны 7 дугаар сар гэхэд бараг бүрэн зогссон хэдий ч хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулснаар 10 сар гэхэд олборлолт, борлуулалтыг хэвийн түвшинд хүргэж, улсын төсөвт 4,114.4 тэрбум төгрөгийг бүрдүүлж чадлаа. Тэрчлэн төсвийн орлогын томоохон хувийг бүрдүүлэгч эрдэс баялгийн салбар дахь төрийн өмчит компаниуд цар тахлын үеийн төсвийн орлогыг тасалдуулахгүй байхын тулд чармайн ажиллаж, иргэдийн амьжиргааг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэн төр засгийн ачааг хуваалцлаа.

ОУИТБС-ын хувьд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлыг харгалзан Олон улсын удирдах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу Үндэсний нэгтгэл тайланг (2020 оны мэдээллээр бэлтгэсэн) уян хатан нөхцөлөөр хийж гүйцэтгэлээ. Өөрөөр хэлбэл, өмнөх тайлангуудад 200 орчим компани хамрагдаж ирсэн бол энэ жил зөвхөн алт, зэсийн баяжмал үйлдвэрлэгч 60 аж ахуйн нэгжийг л хамруулсан юм. 2020 оны байдлаар нийт 2,363 тусгай зөвшөөрөл эзэмшигч компани байснаас 1,419 компани ил тод байдлын тайлан гаргасны дөрвөн хувь нь тулган баталгаажуулалтад хамрагдлаа. Тэрчлэн олборлох салбарт ил тод байдлыг хэрхэн хангаж байгаагаа олон улсад үнэлүүлдэг баталгаажилтын үйл явц 2021 онд

эхэллээ. Цар тахлын үед ийнхүү цахимаар хийгдэж буй ОУИТБС-ын баталгаажуулалтын дүн 2022 онд гарах болно.

Түүнчлэн ННФ-ын анхаарал хандуулан ажиллаж ирсэн эрдэс баялгийн гэрээ, эцсийн өмчлөгчийн мэдээллийн ил тод байдалд зарим ахиц дэвшил гарсныг дурдах нь зүйтэй. Тодруулбал, 2021 онд батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд эцсийн өмчлөгчийн мэдээлэл, уул уурхайн салбарт байгуулагддаг орон нутгийн гэрээг ил тод болгох зохицуулалт тусав. Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам батлагдсанаар ННФ-ын 2019 онд санаачилга гарган бий болгосон Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг баяжуулах, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах үүргийг төр хариуцахаар болов. Ил тод байдлыг хангахад гарсан эрх зүйн орчны энэхүү өөрчлөлт нь иргэний нийгмийн байгууллагуудын хувьд боломж, бас шинэ сорилтыг авчраад байна. Учир нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай хамт батлагдсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар нэр, төрсөн огноо гэх мэт хувь хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад хязгаарлалт тогтоолоо. Тухайлбал, дээрх мэдээлэл агүүлсан өгөгдлийг боловсруулж ашиглахад мэдээлэл хариуцагч төрийн байгууллагаас зөвшөөрөл авч, гэрээ байгуулах зэрэг шаардлага нь нээлттэй өгөгдлийг дэмжих, олон нийтийн хяналтыг бий болгон, засаглалыг сайжруулах олон улсын зарчим, стандартыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар байна.

2021 оны нийгэм, эдийн засгийн энэхүү амаргүй нөхцөлд бид нийтийн өмчийн удирдлага, зарцуулалт дахь зүй бус нөлөөллийг арилган хүн бүрд хүртээмжтэй өсөлт, хөгжлийг бий болгоход байгалийн баялгаа хэрхэн оновчтой ашиглах асуудлаарх бодлогын шинэчлэлд

оролцон, олон талт хэлэлцүүлэг өрнүүлж, хууль журамд санал зөвлөмж тусгуулах зорилго тавин ажиллалаа. Энэ хүрээнд Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, ил тод байдалд суурилсан

олон нийтийн идэвхтэй хяналт бий болгох, орон нутагт хууль, хүний эрхийн зөрчлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулав.

## ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн уул уурхайн салбарын дараах хууль тогтоомжийг шинэчлэх үйл явц 2021 онд өрнөлөө. Үүнд: Үндэсний баялгийн сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай хуулийн төслүүдийг шинээр боловсруулж байгаа бол Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай, Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн бариад байна. Мөн Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай зэрэг салбарын гол хуулиудыг шинэчлэн найруулах ажил ид өрнөж байгаа ч цар тахлын дараах сорилт тулгарснаас эдийн засгийн өсөлт, нийгэм, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг тэнцвэртэй авч үзэх бодлого энэ салбарын шинэчлэлийн гол цөм болж чадахгүй байна. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд байгаль орчин, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх хариуцлагын тогтолцоог сайжруулах, иргэдийн мэдээлэл, оролцоог хангах асуудал бараг орхигдсон бол Үндэсний баялгийн

сан болон Хөгжлийн сангийн тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай зэрэг Монгол хүн бүрийн эрх ашигт шууд хамааралтай хуулийн төслүүдийг олон нийтээр хэлэлцүүлсэнгүй. Түүнчлэн Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх суурь зарчим болох иргэдийн “мэдэх эрх”-ийг хангахад өндөр ач холбогдолтой Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг батлахад төр засгийн зүгээс ач холбогдол өгөхгүй байна.


Иймд ННФ Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх эрх зүйн шинэтгэлд хувь нэмэр оруулах зорилгоор бодлогын судалгаа хийж, хэлэлцүүлэг өрнүүлэн иргэний нийгэм, орон нутгийн иргэдийн дуу хоолойг бодлого боловсруулагчдад хүргэхэд анхаарч ажиллав. Энэ хүрээнд 2020 онд хийгдсэн Үндсэн хуулийн үзэл санааг тодруулах бодлогын цуврал судалгаанд тулгуурлан хэлэлцүүлэг өрнүүлж, санал шүүмж боловсруулан холбогдох байгууллагуудад хүргэв.





Салбарын иргэний нийгмийн байгууллага, судлаач, мэргэжилтнүүд, орон нутгийн төлөөллөөс бүрдсэн зөвлөх баг байгуулан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын Үзэл баримтлалыг тодорхойлоход салбарын яаманд санал өгч ажиллалаа. Уг саналд эрдэс баялгийн салбарын “шийдвэрийн хэлхээ”-нд үндэслэн төрийн оролцоо, баялгийн өмчлөл, түүнээс үүдэн гарах эрх үүргийг тодорхойлохоос эхлээд эрэл, хайгуул, олборлолт, боловсруулалт, татвар, санхүүгийн орчин, дэд бүтэц, орлогын хуваарилалт, байгаль орчин, нийгмийн сөрөг үр дагавраас сэргийлэх хүртэлх бүх шатыг хамарсан цогц зөвлөмжийг тусгав.

Мөн Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахад УУХҮЯ-нд техникийн туслалцаа үзүүлэн, холбогдох судалгаа, шинжилгээний ажлуудыг дэмжив. Шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажилд бодлогын зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Ажлын хэсэгт ННФ гишүүнээр ажиллаж, ил тод байдал, оролцоо, төр, хувийн хэвшлийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зарим зохицуулалтыг тусгууллаа. Цаашдаа уул уурхайтай холбогдон орон нутагт үүсдэг тулгамдсан асуудлуудыг орон нутгийн иргэдийнх нь оролцоотойгоор шийдвэрлэх яриа хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлагатай байна.



**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулагчдад хүргүүлсэн саналын хэсгээс...**

- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендерийн код, худалдан авах гэрээ, гэрээний дүн, хэрэгжилтийн мэдээлэл, үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, үнэлгээний хорооны гишүүдийн нэр, албан тушаал зэрэг мэдээллийг нэмж тусгах зохицуулалт оруулах;
- Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем нь Шилэн данс, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сантай харилцан мэдээлэл солилцдог байх зохицуулалт тусгах.


“Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын худалдан авалтын үйл ажиллагааны ил тод байдал” цахим хэлэлцүүлэг, 2021 оны 4 дүгээр сарын 28.

Төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдал, ТУЗ-ийн томилгоо, хараат бус байдал, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр судалгаа хийж, Үндэсний баялгийн сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслүүдэд санал шүүмж өгөв. Төлсөн Авснаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэлтэй хамтран Үндэсний баялгийн сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг нийтэд ил тод болгох, хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлага гаргаснаар нийтэд нээлттэй бус байсан дээрх хуулийн төслүүд нийтлэгдэв.

Шилэн данс, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд үндэслэн хийсэн Төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авалтын

ил тод байдал судалгааны тайланд үндэслэн шүүмж боловсруулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулагчдад хүргүүлээд байна.

Орон нутгийн иргэдийн эрх ашигтай салшгүй холбоотой Газрын багц хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж, ТАН эвсэлтэй хамтран санал хүргүүлснээс гадна хуулийн төслийг орон нутгийн иргэдэд танилцуулах хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав. ТАН эвсэл болон Хүний эрх хөгжил төв ТББ-тай хамтран цахимаар зохион байгуулсан уг хэлэлцүүлэгт зүүн болон говийн бүсийн долоон аймгийн 92 сумын 600 гаруй хүн оролцлоо.



Газрын багц хуулийн хэлэлцүүлэг: Зүүн гар талаас Зүүн бүсийн хэлэлцүүлэг, 2021. 06.29;  
Говийн бүсийн хэлэлцүүлэг, 2021.07.06.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх зэрэг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимд харшлах болон ил тод байдал, олон нийтийн хяналт, оролцоог хязгаарлах эрсдэлүүдийг тодорхойлов.

Бид сүүлийн жилүүдэд эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангахад төр, хувийн хэвшлийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлууд хийж ирсэн. 2020 онд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулахад идэвхтэй оролцож, холбогдох тооцоо судалгааг хариуцан гүйцэтгэв. Гэтэл боловсруулагдаад бараг хоёр жил болж

буй хуулийн төслийг Засгийн газар, УИХ-ын түвшинд хэлэлцүүлэн батлуулах ажилд дорвитой ахиц гарсангүй. Иймд ТАН эвсэлтэй хамтран уг хуулийн төслийг УИХ-д өргөн барих талаар УУХҮЯ-нд хандаж шаардлага гарган УИХ-ын дарга Г.Занданшатартай уулзаж санал

солилцов. Түүнчлэн Нээлттэй засаглалын түншлэлийн Үндэсний IV төлөвлөгөөнд эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах асуудлыг хуулиар баталгаажуулах үүрэг амлалтыг тусгууллаа.

## ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ИЛ ТОД БАЙДЛЫГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАХ НЬ

ННФ нь Монгол Улс дахь ОУИТБС-ыг дэмжих, тэр дундаа гэрээ болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангахад хүчин чармайлт тавьж ирсэн бол харин сүүлийн жилүүдэд нэгэнт бий болсон ил тод байдлыг бодит өөрчлөлт болгон хариуцлага, хуулийн хэрэгжилтийг төлөвшүүлэхэд үр дүнтэй ашиглах, энэ чиглэлээр иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэхэд илүүтэй анхаарч байна.

Энэ хүрээнд 2020 онд зохион байгуулсан “Уул уурхайг өгөгдлөөр урлахуй” цахим хакатоны үеэр хийгдсэн засаглалын чухал асуудлуудыг хөндсөн бүтээлүүдийг олон нийтэд хүргэхэд анхаарч ажиллав. Дата шинжилгээ, график дүрслэл, сэтгүүл зүйн үр чадварыг нэгтгэсэн залуучууд баг болж ажилласнаар хандив дэмжлэгийн үр нөлөө, орон нутагт уул уурхайгаас орлого төвлөрүүлдэг сангуудын засаглал, ил тод байдал, төрийн өмчит компаниудын худалдан авалтын ил тод байдлыг хөндсөн дата сэтгүүл зүйн хоёр бүтээл олон нийтийн хүртээл боллоо. Үүнээс DW багийн “Хөгжлийн сан нэртэй ёроолгүй савнуудад хуулийн дэнс хэрэгтэй” цуврал нийтлэл нь Монголын хэвлэлийн хүрээлэнгийн 25 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан эдийн засгийн сэтгүүл зүйн оны шилдэг бүтээл шалгаруулах уралдаанд дэд байр эзэлсэн юм. Мөн *Research Squad* багийн нийтлэл *Facebook* болон мэдээллийн цахим сайтуудаар түгснээр 10,000 гаруй хүнд хүржээ (эдгээр бүтээлийг сонирхвол <https://ikon.mn/n/2cod> болон

<https://ikon.mn/n/2eng> линкээр орж үзнэ үү). Цаашид эрдэс баялгийн салбарын орлогын менежмент, тусгай зөвшөөрөл олголтын ил тод байдал, орон нутгийн гэрээ, нөхөн сэргээлтэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх асуудлыг дэвшүүлсэн бүтээлүүдийг цувралаар хүргэх юм.

Түүнчлэн нийтийн баялгийн зарцуулалтад олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн өмчит компаниудын худалдан авалт, борлуулалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийн, төрийн өмчит компанийн төсөв хөрөнгийн зарцуулалт дахь эрсдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн гогцоог баримттайгаар гарган харуулав. Мөн төрийн байгууллагуудын мэдээллийг холбосон өгөгдлийн нэгдсэн сан үүсгэж, дүн шинжилгээний программ хөгжүүлсэн нь нийтийн баялгийн зарцуулалтыг хянах идэвх санаачилгыг өрнүүлэхэд ач холбогдолтой зүйл боллоо. Уг үйл ажиллагаа цаашид үргэлжлэн удахгүй нээлттэй болох эцсийн өмчлөгчийн мэдээллээр уг санг баяжуулан тогтмол шинэчлэхийн сацуу төрийн байгууллагуудын өгөгдлийн менежментийг сайжруулах, иргэний нийгэм, сэтгүүлчдийг бэлтгэх чиглэлээр өрнөх юм. Өгөгдлийн шинжилгээнд суурилсан сэтгүүл зүйн “Нээлттэй өгөгдлийн далд боломжийг нээхүй”, “Хаалттай” өгөгдлийн сангуудад аминчхан зөвлөө”, ЖДҮ-үүд ТӨК-үүдэд юу нийлүүлдэг вэ” зэрэг бүтээлийг [dataclub.medium.com](https://dataclub.medium.com) линкээр орж үзнэ үү.



*Business.mn подкастаар төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авалтад хийсэн өгөгдлийн дүн шинжилгээний үр дүнг танилцуулав. Зүүн гар талаас сэтгүүлч Г.Даваадорж, Монголын дата клубийн зөвлөх, дата архитектор, МУИС-ын багш Г.Амарсанаа, Монголын дата клубийн гишүүн, сэтгүүлч З.Цэлмэг, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг нар.*



*Монголын дата клубийн гишүүд "Дата эрх чөлөө: Мэдэх эрх" үзэсгэлэнгийн үеэр, 2021.12.06.*

Тусгай зөвшөөрөл олгох үйл явцад хяналт тавих хүрээнд дүйцүүлэх журмаар тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрүүдэд мониторинг хийж байна. 2017 онд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх зорилгоор тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг төрийн мэдэлд шилжүүлэн авч, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн талбайд тусгай зөвшөөрөл дүйцүүлэн олгох болсон. Гэхдээ ийнхүү дүйцүүлэн олгох үйл явцыг нарийвчлан зохицуулаагүйгээс АМГТГ тусгай зөвшөөрөлтэй холбогдох маргааныг дүйцүүлэх нэрээр

зөвшөөрөл олгож шийдвэрлэсэн байх магадлал байгаа юм. Мониторингийн явцад цугларсан мэдээллээс харвал Засгийн газраас тусгай зөвшөөрлийг дүйцүүлэн олгох шийдвэрийг 2017 онд ганц удаа гаргасан байх ба тусгай зөвшөөрлийн талбай нь улсын тусгай хамгаалалтад авсан газар нутагтай давхацсан үндэслэлээр 18 зөвшөөрөл олгожээ. Харин 2020 онд Дорноговь аймгийн Айраг, Булган аймгийн Тэшиг, Төв аймгийн Заамар суманд дүйцүүлэх журмаар тусгай зөвшөөрөл олгогдсон байх боловч үүнтэй холбоотой Засгийн газрын шийдвэр байхгүй байгаа нь ажиглагдлаа.



## ОРОН НУТАГТ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Орон нутгийн захиргаа, компаниудын хариуцлагыг дээшлүүлж, байгаль орчин, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор уул уурхай, газрын тосны салбарт хийгддэг хяналт шалгалтын тогтолцоо, үр нөлөөг үнэлэх судалгааны ажлыг 2020

онд эхлүүлсэн билээ. Уг судалгаанд уул уурхайн хувьд байгаль орчны хяналт шалгалтын тогтолцоог сонгон авч судалсан бол газрын тосны салбарын хувьд санхүүгийн хяналт шалгалтын үр нөлөөг авч үзсэн юм.



Уул уурхайн байгаль орчны хяналтыг УУХҮЯ, АМГТГ, БОАЖЯ, түүний орон нутаг дахь харьяа агентлагаас эхлээд нутгийн захиргаа, мэргэжлийн хяналт зэрэг төрийн олон байгууллага тус тусын эрх хэмжээгээр хэрэгжүүлдэг ч ялгаагүй шахам, зарим талаар давхардсан хяналт хэрэгжүүлэх тул ач холбогдол, үр нөлөө багатайгаас гадна аж ахуйн нэгжүүдэд багагүй дарамт, ачаалал үүсгэдэг; харин газрын тосны салбарын санхүүгийн хяналт шалгалтын зарим журам, заавар, аргачлал батлагдаагүйгээс олборлолтын үйл ажиллагаа явуулж буй хоёр компанийн төлбөр тооцоонд 2014 оноос хойш огт хяналт шалгалт хийгдээгүй болох нь судалгааны дүгнэлтэд тэмдэглэгджээ.

Уул уурхайн зөрчлийн мэдээллийг орон нутгийн иргэдээс авч мэдээллийн сан үүсгэх, эрхээ хамгаалахад нь туслах зорилго бүхий [www.miningwatch.mn](http://www.miningwatch.mn) цахим системийг

2021 онд хөгжүүлж дүүслаа. Ирэх онд уг цахим системийг орон нутгийн иргэдэд танилцуулж, ТАН эвслийн гишүүд энэ үйл ажиллагаанд зөвлөн тусалж ажиллах болно.

### Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах нь

ННФ нь 2016 оноос төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх хуулийн шинэ боломжуудыг үр дүнтэй ашиглах иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ирсэн билээ. Үүний үр дүнд захиргааны хэргийн шүүхэд гаргасан нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл нэмэгдэхийн хэрээр ТББ-үүд ч мэргэшиж эхэлж байна. Энэ чиглэлээр 2016-2021 онд олгосон 41 тэтгэлгийн хүрээнд 47 өмгөөлөл явагдсанаас 20 нь эцэслэн шийдвэрлэгдлээ. Үүнээс эрдэс баялгийн салбарт холбогдох 11 хэрэгт нэхэмжлэлийн шаардлагыг

бүхэлд нь болон зарим хэсгийг хангах шийдвэр гарчээ. Тухайлбал, 2021 онд Сүхбаатар аймагт хууль бусаар олгогдсон цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлуулж, Баянхонгор аймагт хууль бус нөхөн сэргээлтийн гэрээг хүчингүй болгон, Дорнод аймагт газрын тосны салбарт орон нутгийн гэрээ байгуулах тухай шүүхийн шийдвэр хэрэгжиж орон нутагт 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэв. Мөн Говьсүмбэр аймагт нүүрсний хууль бус тээвэрлэлтийг зогсоож, Орхон аймагт Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын даланд байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийгдэж эхэллээ.





*Эхний зураг дээр Цагаан шорооны хор хөнөөлөөс ирээдүйгээ аврах хөдөлгөөн ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Х.Должинсүрэн Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын далангийн ойролцоо орших Хангалын голоос шинжилгээний дээж авч байгаа нь.*

*Дараах зураг дээр Эх орон хамтын хүч ТББ-ын төслийн багийн гишүүд Айраг сумын иргэдэд Янтай уулын ХХК-ийн хог хаягдлын цэгийн нөхцөл байдлыг танилцуулж байгаа нь.*

Ийнхүү бид энэ чиглэлд иргэний нийгмийн байгууллагуудыг тууштай дэмжин, стратегийн өмгөөллийн хөтөлбөр хөгжүүлэх зорилго бүхий үрт хугацаатай тэтгэлэг олгож эхэлсний үр дүнд сүүлийн жилүүдэд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дагнан ажилладаг байгууллагууд бий болж байна. Тэтгэлгийн хүрээнд Хил хязгааргүй алхам, Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ-ууд нийтийн эрх ашгийн өмгөөллийн хөтөлбөртэй болж, хуульчдын баг бүрдүүлжээ. Мөн Хил хязгааргүй алхам ТББ нь шинэ тутам байгуулагдсан орон нутгийн төрийн бус байгууллагуудад зөвлөн тусалж ажилласнаар Дорноговь аймгийн Айраг сумын Эх орон хамтын хүч, Хатанбулаг сумын Нутаг амь ТББ-ууд орон нутагтаа үүссэн уул уурхайн зөрчлийг арилгуулах нэхэмжлэл гаргахаар бэлтгэж байна.

Хил хязгааргүй алхам ТББ нь төслийн хүрээнд говийн бүсэд хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилго бүхий таван хэрэг сонгон ажиллаж байгаагаас одоогоор шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн болон шүүхийн шатанд тус бүр хоёр хэрэг, нөлөөллийн үйл ажиллагааны шатанд

нэг хэрэг байна. Дээрх хэргүүд дээр 2021 онд хийгдсэн үйл ажиллагаа, гарсан өөрчлөлтийг дурдвал:

- Орон нутагт байгуулагддаг уул уурхайн гэрээнд иргэдийн оролцоог хангах зорилго бүхий нэхэмжлэлийг гурван шатны шүүхээр хэлэлцэн шийдвэрлэлээ. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг дарга уул уурхайн компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулахдаа Захиргааны ерөнхий хуулийг зөрчин иргэдээс санал шүүмж авах ажиллагаа зохион байгуулаагүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагчийн зүгээс сонсох ажиллагаа хийгээгүй, хууль зөрчсөн болохоо хүлээн зөвшөөрснөөр талууд эвлэрлийн гэрээ байгуулжээ. Эвлэрлийн гэрээ нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил заавал биелэгдэх учиртай. Эвлэрлийн гэрээний дагуу сумын Засаг дарга компаниудтай байгуулсан гэрээгээ шинэчлэх, ингэхдээ хуулийн дагуу сонсох ажиллагаа хийх үүрэг хүлээжээ. Уул уурхайн салбарт Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах жишиг тогтоосон уг шийдвэрийг төрийн холбогдох байгууллагууд

болон тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад хүргүүлээд байна.

- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай дансны орлого, зарлагын мэдээллийг ил тод болгох нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч БОАЖЯ хүлээн зөвшөөрч, Эвлэрлийн гэрээ байгуулсан. Үүний дагуу 2022 оны эхний улиралд багтаан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай дансны мэдээллийг ил тод болгох ажил хийгдэж эхэлжээ.
- Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн явцад гарч буй хүрээлэн буй орчин, хүний эрхийн зөрчлийг таслан зогсооход анхаарч ажилласнаар Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр аймгийн нутгаар дамжин өнгөрдөг шороон замын нүүрс тээвэрлэлтийн ажиллагааг зогсоож чадсан. Үр дүнд нь Тавантолгойн бүлэг ордоос Ханги мандалын хилийн боомт хүртэл 470 км хатуу хүчилттай зам барих шийдвэр 2021 онд гарч концессын гэрээ байгуулагджээ. Гэвч концессын гэрээг сонгон шалгаруулалт зарлалгүйгээр тендерийн шаардлага хангаагүй компанитай байгуулсан зөрчил гаргаж, мөн сонсох ажиллагаа хийгээгүй байна. Иймд уг гэрээг илт хууль бусд тооцуулах нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхэд гаргаад байна.
- Дорноговь аймгийн Айраг суманд орших Цагаан дэлийн агуй, түүний орчимд явагдаж буй уул уурхайн хариуцлагагүй үйл ажиллагааг баримтжуулан, холбогдох талуудын анхаарлыг хандуулснаар Цагаан дэлийн агуйн орчмын газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад оруулсан ба одоо хилийн заагийг тодорхойлоход оролцож байна. Тэрчлэн тус бүс нутагт ХЭҮК-оос уул уурхайгаас үүдэлтэй хүний эрхийн нөлөөллийг тогтоох үнэлгээ хийсэн бол БОАЖЯ-ны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус аймгийн Даланжаргалан, Айраг

суманд уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн бий болсон байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх ажил тусгагдсан байна. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас уул уурхайн үйл ажиллагааны нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний журам, аргачлал боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч эхэлжээ.

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход Усны сав газрын саналыг үндэслэх, Усны тухай хуулийн 17.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх асуудлаар УУХҮЯ-ны эсрэг нэхэмжлэл гаргасан нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байна.

Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ нь Эко хуульчдын клуб байгуулан, дараах асуудлууд дээр ажиллаж байна. Үүнд:

- Усны бохирдлын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй Засгийн газрын эс үйлдэхүйг илт хууль бус болохыг тогтоолгох хэрэгт ялалт байгуулснаар БОАЖЯ-аас усны бохирдлын төлбөр тооцох аргачлал боловсруулах ажил эхлээд байна. Тэрчлэн Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, уул уурхайн компаниудыг усны бохирдлын төлбөрөөс чөлөөлөх гэж байсныг зогсоож чаджээ. Тэрчлэн Ашигт малтмалын тухай хуульд байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлээгүй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үчруулсан бол тусгай зөвшөөрлийг цуцлах зохицуулалтыг тусгуулжээ.
- Тусгай хамгаалалттай газар нутагт газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нь хянан шийдвэрлэгдэх шатанд байна.

2021 онд нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах чиглэлээр гурван тэтгэлэг олгоод байна. 2019 оны

Өмгөөллийн тухай хуулийн шинэчлэлээр өмгөөлөгч нийтийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломж нээгдсэн. Хуулийн энэхүү боломжийг ашиглах жишиг тогтоох зорилгоор өмнө нь зөвхөн төрийн бус байгууллагуудын дунд зарладаг байсан нийтийн эрх ашгийн өмгөөллийн тэтгэлэгт хөтөлбөрт энэ онд хуульчдыг нэмж хамруулав. Ингэснээр өмгөөлөгч Г.Мандахсайхан ахлагчтай хуульчдын баг тэтгэлэг авч улсын тусгай хамгаалалттай газар нутагт хууль бусаар газар ашиглах эрх олгосон асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмал, газрын тосны газартай гэрээ байгуулж, холбогдох зардлыг улсад эргүүлэн төлөх ба энэ үүргээ хэрэгжүүлээгүй бол гэрээг цуцалж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хуулийн зохицуулалттай.

БОАЖЯ Горхи, Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт 160 гаруй албан хаагчдаа зуслангийн зориулалтаар газар олгосон нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг зөрчөөд зогсохгүй, тэнд үе дамжин амьдарч ирсэн нутгийн иргэдийн эрх ашгийг зөрчсөн юм. Төслийн хүрээнд төрийн захиргааны байгууллагын дээрх хууль бус шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэл гаргасан нь захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж байна. Хуульчдын баг уг хэргийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж байгаа нутгийн иргэдийг мэдээллээр хангах, хэлэлцүүлэг зохион байгуулах, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн төсөлд санал боловсруулж хүргүүлэх зэрэг нөлөөллийн ажлуудыг хийжээ.

Хонгор нутгийн дуудлага ТББ улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ажлын зардлыг нөхөн төлөх гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй Спэйшл Майнз компанийн гэрээг сонгон нэхэмжлэл гаргаад байна. Сүүлийн жилүүдэд энэхүү гэрээний хэрэгжилт хангалтгүй бөгөөд гэрээний үүргээ зөрчсөн компаниудад хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх явдал сул байгаа юм.



*Зүүн гар талаас: Төслийн багаас зохион байгуулсан Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн байдал ба суурьшлын бүс хэлэлцүүлгийн үеэр Налайх дүүргийн 6 дугаар хорооны засаг дарга Л.Болд сэтгүүлчдэд ярилцлага өгч байгаа нь; дараагийн зурагт төслийн багийн өмгөөлөгч Г.Ургамалцэцэг, багийн гишүүн Д.Цэрэндагва, нэхэмжлэгч иргэн н.Ганхуяг нар, 2021.11.10.*

Түүнчлэн орон нутагт нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах чадавх бүрдүүлэх зорилгоор Дорнод аймгийн Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн ТББ-д хоёр жилийн хугацаатай тэтгэлэг олголоо. Тус байгууллага тэтгэлгийн хүрээнд газрын тосны нөөц ашигласны төлбөрийг орон нутагт хуваарилах асуудлаар нэхэмжлэл гарган хуулийн хэрэгжилт, ил тод байдлыг сайжруулахад залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах юм. Тус хөдөлгөөн нь сүүлийн 10 гаруй жил газрын тосны салбарт хуулийн хэрэгжилт, хариуцлага шаардан тасралтгүй ажиллаж байгаа, нийтийн эрх ашгийн өмгөөллийн арвин туршлагатай байгууллага юм. 2011 онд газрын тосны үйлдвэрлэлээс үүдэлтэй байгаль орчны хохирлын

нөхөн төлбөр гаргуулсан бол 2019 онд мөн энэ салбарт орон нутгийн гэрээ хийх жишиг тогтоож чаджээ. Үүний үр дүнд Дорнод аймгийн Халхгол, Матад сумдад газрын тосны компаниудаас 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд байна.

Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах жишиг тогтоосон шүүхийн шийдвэр, өмгөөллийн үр дүнг сурталчлах, төрийн бус байгууллагуудын нөлөөллийн үр чадварыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төрийн бус байгууллагуудад олгосон тэтгэлгийн үр дүнгээр 2021 онд нөлөөллийн 48 бүтээгдэхүүн гарч, 106,950 орчим хүнд хүрчээ.



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ПОСТЕР

Хууль зөрчил үйлдэгчид "ЛАНЬТАЙ-УУЛ" ХХК-ийн байгуулалт үйлдвэрлэлтэй хамт байгуулалт гэж байгаа нь үнэнд нийцэхгүй!!!

Мэргэжлийн гэрээний үндсэн дээр ХХК-ийн хөрөнгө өөр хуульдаа ил хуульчлан хураахыг хориглоно

**ЗӨРЧИЛ**

- Газрын эзэмшлээ тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 20-р аймаг, 26-р дүүрэгт байрлана.
- Байрны эзэмшлээ тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 20-р аймаг, 26-р дүүрэгт байрлана.
- Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр 20-р аймаг, 26-р дүүрэгт байрлана.
- Байрны эзэмшлээ тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 20-р аймаг, 26-р дүүрэгт байрлана.

БНМАУ-ын харьяат орнуудтай "ЛАНЬТАЙ-УУЛ" ХХК-ийн Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн баримтаас...

2018 онд УИХЕГ-ийн дүгнэлтээр энэ төвөг үйл ажиллагааг нь зогсоосон. Гэвч дахин амжилал гаж байна.

Энэ амжилал бүтээгдэхүүн хэргийг төсвийн дотоо нэгдсэн үйлдвэрлэлтэй хамт байгуулалт гэж үзжээ.

Тухайн үйлдвэр байрны эзэмшлээ тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 20-р аймаг, 26-р дүүрэгт байрлана.

Хуульчлан хураахыг хориглоно.

Хуульчлан хураахыг хориглоно.

200 метрээр дахин өргөсгөвөд

ХАРИУЦЛАГА

КАРГОТРИЙН ЗӨРЧЛӨӨД ДАВХАДСАН

ТӨВӨГ ӨЗӨВШИНЭ, АШИГЛАХ ЗӨВЧЛӨӨН ДЭМЖЭГЭЙН ХАРИУЦЛАГА

2016-2017-ОНЫ 600 МИЛДИЙН ИТМЖ ГЭЛЭЭР ӨЖӨӨ

АНЬГУЙ ХУУЛЬ

**ШҮҮХИЙН ШИИДВЭР ГАРЛАА**

ТАВИ ТАЛД

- 1 ХУУЛЬ БУС ОЛБОРЛОЛТ
- 2 ХУУЛЬ БУСААР ТӨСӨВ БҮРДҮҮЛЭЛТ
- 3 ЭРХ МЭДЛЭЭ УРВУУЛАН АШИГЛАХ
- 4 ХУУЛЬ БУС ЗАХИРГААНЫ АКТ

**ШҮҮХ ТАСЛАН ЗОГСООЖ ИРГЭДИЙН ТАЛД ШИИДВЭРЛЭЛЭЭ**

Гадна тохижилтоо хий!!!

**Гадна ТОХИЖИЛТГҮЙ "Ховд Юхо" ХХК-ны барьсан 30 айлын орон сууц**

ХУУДИЙН ТӨГӨЛДӨМӨН ТӨЛБЭЙ ЖЭРЭГТЭЙ БАЙНА.

2017-2018 ОНУУДАД АЖИГАВТАД ОРСОН

Уулзурхай-Байгалийн сүрэн-Иргэдийн сүрэн

**УЛС ТӨРИЙН ҮЗЛЭЭР АЖЛААС ХАЛАХ НЬ ХУУЛЬ БУС**

ХУУЛЬ БУС ШИИДВЭР ГАРГАСАН АЛБАН ТУШААЛТГААС ТӨРД УМЬРСАН ХААЛРЫНГ НОНХОН ТӨЛӨҮҮЛЭЭ.

Амьд хууль ТББ



# САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Нээлттэй Нийгэм Форум 2021 онд нийт 2,023,235 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 2,018,635 нь Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон түүний сүлжээний хөтөлбөрүүд, \$4,600 нь бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

## НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
<b>АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ</b>			
Ардчиллын институцийг бэхжүүлэх нь	103,513	178,840	282,354
Иргэний оролцоог дэмжих нь	91,635	174,423	266,058
<b>ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО</b>			
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	32,438	239,951	272,388
Хүний эрх	32,870	67,599	100,469
Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг дэмжих нь	18,155	135,616	153,771
<b>НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ</b>			
Төсвийн хариуцлагыг сайжруулах нь	53,142	180,662	233,804
Эрдэс баялгийн салбарт сайн засаглалыг дэмжих нь	56,415	168,403	224,818
<b>ЗАХИРГАА</b>	-	416,905	416,905
<b>НИЙТ ДҮН</b>	<b>388,168</b>	<b>1,562,399</b>	<b>1,950,567</b>

## НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ ам.доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт тэтгэлгийн зардал
<b>АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ</b>			
Ардчиллын институцийг бэхжүүлэх нь	97,197	6,316	103,513
Иргэний оролцоог дэмжих нь	91,635	-	91,635
<b>ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ БОДЛОГО</b>			
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	24,002	8,436	32,438
Хүний эрх	32,870	-	32,870
Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг дэмжих нь	18,155	-	18,155
<b>НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ</b>			
Төсвийн хариуцлагыг сайжруулах нь	53,142	-	53,142
Эрдэс баялгийн салбарт сайн засаглалыг дэмжих нь	49,674	6,741	56,415
<b>НИЙТ ДҮН</b>	<b>366,675</b>	<b>21,493</b>	<b>388,168</b>

## 2021 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн	
					Төгрөг	Ам.доллар
1	Улаанбаатар	Их Бага Баяншарга	Гурвансайхан ХХК-д олгогдсон уран олборлох тусгай зөвшөөрлийг цуцлуулах стратегийн өмгөөлөл хийх	ТББ	5,000,000	1,755
2	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	Бодлогын цахим нөлөөлөл	ТББ	11,000,000	3,860
3	Улаанбаатар	Амьд хууль төв	Хариуцлагатай Засаглал	ТББ	7,672,200	2,692
4	Улаанбаатар	Цагаан шорооны хор хөнөөлөөс ирээдүйгээ аврах хөдөлгөөн	Цагаан шорооны хор хөнөөлөөс ирээдүйгээ аврах төсөл	ТББ	8,000,000	2,807
5	Улаанбаатар	С.Сүхчулуун	Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг маргаан дахь хууль хэрэглээ буюу "Хангалттай сонирхол илэрхийлэх": ЗХШХШТХ-ийн 52.5.5 дахь заалтыг хэрэглэсэн байдал (Хууль тогтоогчийн үзэл санаа ба шүүхийн шийдвэр дэх хууль хэрэглээний тайлбар)	Иргэн	3,000,000	1,053
6	Улаанбаатар	Сайн туршлага	Иргэний хуулийн 413-419 дүгээр зүйл буюу худалдааны зүүчлагч, төлөөлөгч, комиссын зохицуулалтыг хэрэглэж шийдвэрлэсэн хэрэг маргаанд хийсэн дүн шинжилгээ	ТББ	7,177,246	2,518
7	Улаанбаатар	Б.Амарсанаа баг	Цахим хэлбэрээр хийсэн гэрээний (цахим хэлцэл) маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	Баг	6,772,000	2,376
8	Улаанбаатар	Эрх зүйн хөгжлийн төлөө	Арбитрын шийдвэртэй холбоотой Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээ, практик, тулгамдсан асуудал	ТББ	5,600,000	1,965
9	Улаанбаатар	Хөгжлийн эрх зүйн төв	Эрүүгийн хуульд шинээр тусгасан гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик	ТББ	5,175,000	1,816

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн	
					Төгрөг	Ам.доллар
10	Улаанбаатар	Судлаач соно бодлого судалгааны төв	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргааныг иргэний хэргийн хэргийн шүүх шийдвэрлэж буй байдал	ТББ	6,300,000	2,211
11	Улаанбаатар	Б.Энхбаяр	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх	Иргэн	4,770,000	1,674
12	Улаанбаатар	Санхүү, бизнесийн эрх зүйн судалгааны хүрээлэн	Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шийдвэрийн дүн шинжилгээ	ТББ	4,240,000	1,488
13	Улаанбаатар	Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн	Шүүхийг тойргийн зарчмаар болон дагнасан хэлбэрээр зохион байгуулах үндэслэл, шаардлага: Харьцуулсан судалгаа	ТББ	8,600,000	3,018
14	Улаанбаатар	Сонгогчдын боловсрол төв	Сонгогчдын мэдлэг, мэдээлэлтэй оролцоогоор дамжуулан ардчиллын боловсролыг түгээх нь	ТББ	44,297,000	15,543
15	Улаанбаатар	Глоб интернэшнл	Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүргийг хөхиүлэн дэмжих нь	ТББ	22,595,000	7,927
16	Улаанбаатар	Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв	2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеийн фэйсбүүк дэх хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний хэрэгжилтийн мониторинг	ТББ	18,781,250	6,589
17	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	Улс төрийн санхүүжилт ба сонгууль	ТББ	86,800,000	30,453
18	Улаанбаатар	Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв	Байгууллагын үйл ажиллагааг дэмжих тэтгэлэг	ТББ	51,291,900	18,000
19	Улаанбаатар	Хөгжлийн эрх зүйн төв	Шүүхийн шийдвэрийн ил тод байдлын мониторинг	ТББ	11,917,500	4,183

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн	
					Төгрөг	Ам.доллар
20	Улаанбаатар	Өмгөөллийн "Номун Түншлэл"	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх стратегийн өмгөөлөл	ХХК	15,000,000	5,265
21	Ховд	Шинэ эвлэл орон нутгийн сэтгүүлчдийн холбоо	"Цагаан эрэг"-ийн хохирлыг арилгах стратегийн өмгөөлөл	ТББ	15,372,000	5,396
22	Улаанбаатар	Өмгөөллийн Фиделитас Партнерс	"Ковид -19 цар тахлын үед захиргааны хууль бус шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг барагдуулах" төсөл	ХХН	6,000,000	2,106
23	Улаанбаатар	Өмгөөллийн Барристер Кастос	Гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг арилгах жишиг тогтоох	ХХК	15,348,000	5,388
24	Улаанбаатар	Өмгөөллийн Фиделитас Партнерс	"Ковид 19 үед хандив тусламжийн зарцуулалтын ил тод байдал, хангамжийг сайжруулах" төсөл	ХХН	15,000,000	5,265
25	Улаанбаатар	Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо	Төрийн өмчит уул уурхайн компаниудын төсөв хөрөнгийн зарцуулалтад олон нийтийн хяналт бий болгох нь - түршилтын өгөгдлийн шинжилгээний төсөл	ТББ	40,165,000	14,099
26	Улаанбаатар	Г.Мандахсайхан	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах нь	Баг	15,000,000	5,263
27	Баянхонгор	Хонгор нутгийн дуудлага	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээний хэрэгжилтийг хангуулах нь	ТББ	9,797,900	3,438
28	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгож буй хэлбэрүүд	ТББ	6,410,000	2,249
29	Улаанбаатар	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоо	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломж	ТББ	10,820,000	3,797
30	Улаанбаатар	Ч.Алтан-Өлзий	Уул уурхайг сансраас тандахуй	Баг	3,691,800	1,295



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн	
					Төгрөг	Ам.доллар
31	Улаанбаатар	З.Цэлмэг	Хандив гэдэг хаялга бус	Баг	3,691,000	1,295
32	Улаанбаатар	Д.Лхамсүрэн	Уул уурхайн орлогын менежмент	Баг	2,545,280	893
33	Улаанбаатар	Э.Должин	Төрийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны ил тод байдал ба тендерт шалгарсан компаниудын эцсийн өмчлөгч	Баг	3,948,000	1,385
34	Улаанбаатар	Б.Мөнх-Оргил	Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээн дэх иргэдийн оролцоо, хяналт	Баг	705,000	247
35	Ховд	Жавхлант гэрэлт ирээдүй	Ховд аймаг дахь БОЭТ-ийн дэргэдэх 50 ортой Хүүхдийн эмнэлэгийн барилгын чанар, гүйцэтгэлд хариуцлага тооцуулах буюу улс орон нутгийн төсвийн зарцуулалтын хариуцлагыг сайжруулах нь	ТББ	12,498,750	4,386
36	Улаанбаатар	Э.Түвшинтөр	Тусгай зөвшөөрөл олголтын системийг цогц цахим хэлбэрт шилжүүлж, сайжруулах замаар Иргэдийн бодит хяналт, оролцоог хангах	Баг	4,628,000	1,624
37	Ховд	Ховдын толь сонин	Эрдэс баялгийн салбар дахь хариуцлага, ил тод байдал-стратегийн өмгөөллийн хөтөлбөр	ТББ	72,160,000	25,326
38	Баянхонгор	Амьд хууль төв	Нийтийн эрх ашиг, нийтийн өмчийг хамгаалах, өмгөөллийг бэхжүүлэх	ТББ	69,012,600	24,221
39	Улаанбаатар	Бүйрнуур халх гол нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулснаар байгалийн баялгийг иргэд шударгаар хүртэх, орон нутгийн хөгжил үр дүнд хүрэхийн төлөө	ТББ	91,594,400	32,147
40	Улаанбаатар	Үнэн хатамж нийгэмлэг	Төсвийн хяналт, бидний оролцоо	ТББ	49,763,550	17,466
41	Улаанбаатар	Хүний эрхийн Үндэсний Комисс	Байгууллагын чадавх бэхжүүлэх төсөл	Төрийн байгууллага	70,000,000	24,568

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн	
					Төгрөг	Ам.доллар
42	Улаанбаатар	Хөгжлийн эрх зүйн төв	Заналхийлэх гэмт хэргийн судалгааны үр дүнг олон нийтэд хүргэх нөлөөллийн ажил	ТББ	12,721,960	4,465
43	Улаанбаатар	Г.Цэцгээ	Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх	Иргэн	5,000,000	1,755
44	Улаанбаатар	Онч шийдэл	Төрийн байгууллага, албан тушаалтны албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн үлмээс төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нэхэмжлэхтэй холбоотой нэхэмжлэгч байгууллагын шаардах эрхийг хэрхэн тодорхойлж байгаа талаарх шүүхийн практик	ТББ	8,386,400	2,943
45	Улаанбаатар	Хүний эрхийн Үндэсний Комисс	Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулах "Хүний эрхийн үндэсний форум"	Төрийн байгууллага	23,654,900	8,302
46	Улаанбаатар	Д.Ганхүрэл	Дуусаагүй барилгын эд хөрөнгийн эрх шилжихтэй холбогдох шүүхийн практик дах хууль хэрэглээний зарим асуудал	Иргэн	7,497,000	2,631
47	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачлага	Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэхийг дэмжиж	ТББ	89,150,000	31,290
48	Улаанбаатар	Тогтвортой хөгжлийн төлөө сэтгүүл зүй	Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтийн сүлжээгээр сурталчлан таниулах төсөл	ТББ	61,200,000	21,480
49	Улаанбаатар	Глоб интернэшнл	Ардчиллын институциудийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд "Төрийн мэдээллийн ил тод байдлын мониторинг, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах" нь	ТББ	46,304,000	16,252
<b>ДҮН</b>					<b>1,106,054,636</b>	<b>388,168</b>

## НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

### Удирдах Зөвлөлийн гишүүд

---

О.Мөнхсайхан	Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн ХЗС-ийн профессор, Хууль зүйн доктор
Г.Уранцоож	Удирдах зөвлөлийн гишүүн, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Ж.Үнэнбат	Удирдах зөвлөлийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын зөвлөх
Ч.Лодойравсал	Удирдах зөвлөлийн гишүүн, МУИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан Дэд захирал (2021 оны эхний хагас жил хүртэл ажилласан)
П.Наранбаяр	Удирдах зөвлөлийн гишүүн, Сайн сургуулийг таны дэргэд ТББ-ын тэргүүн
Д.Энхжаргал	Удирдах зөвлөлийн гишүүн, МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний Ерөнхий зохицуулагч
Ч.Болортуяа	Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхий сайдын хэвлэлийн төлөөлөгч, зөвлөх

### Гүйцэтгэх захирал

---

П. Эрдэнэжаргал

### Ажилтнууд

---

П.Бадамрагчаа	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
А.Гэрэлмаа	Иргэний оролцооны хөтөлбөрийн менежер
Д.Оюунбадам	Засаглалын хөтөлбөрийн менежер
Б.Хишигсайхан	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
Д.Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
Д.Эрдэнэчимэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
О.Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан
Б.Ундармаа	Хөтөлбөрийн туслах ажилтан
Б.Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан
Д.Балжид	Мэдээллийн менежер
Б.Мөнхгэрэл	Мэдээллийн ажилтан
Д.Жавхлан	Захиргаа, Санхүүгийн захирал
Ж.Алтанчимэг	Тэтгэлгийн менежер
В.Халиунцэцэг	Нягтлан бодогч
Э.Сайнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч
Б.Амгалан	Захиргааны ажилтан
Б.Баатар	Захиргааны туслах ажилтан
Г.Цэдэвхүү	Захиргааны туслах ажилтан
Б.Бат-Эвлэл	Захиргааны туслах ажилтан

---

Нийтлэг И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)



## ЖИЛИЙН ТАЙЛАН 2021

---

Нээлттэй Нийгэм Форум  
Жамьян гүний гудамж - 5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240, Монгол Улс  
Утас: 76113207  
<http://www.forum.mn>  
<http://www.twitter.com/ForumOS>  
<http://facebook/OpenSocietyForum>  
[http://www.instagram.com/open\\_society\\_forum](http://www.instagram.com/open_society_forum)